

МОНГОЛДОО САЙХАН АМЬДАРЪЯ



АМЬДРАЛ

ИРГЭНИЙ ЗОРИГ НОГООН НАМЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨР



ИЗНН-ын Үндэсний Хорооны хурлын 2012 оны 05 сарын 1-ний өдрийн 06 тоот тогтоолоор батлав.

ИРГЭНИЙ ЗОРИГ НОГООН НАМЫН 2012 ОНЫ УИХ-ЫН СОНГУУЛИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР

- Хувь хүний амьдрал
- Өрх гэрийн амьдрал
- Хотын амьдрал
- Орон нутгийн амьдрал
- Улс орны амьдрал

Гарчиг

НЭГ. АМЬДРАЛЫН ТУХАЙ ТОО БАРИМТУУД

3

ХОЁР. ИРГЭДЭЭР ОВОГЛОСОН, ИРГЭДИЙН ТӨЛӨӨ, ИРГЭД НЬ
ХЭРЭГЖҮҮЛЭХ "АМЬДРАЛ" МӨРИЙН ХӨТӨЛБӨР

10

- ХУВЬ ХҮНИЙ АМЬДРАЛ
- ӨРХ ГЭРИЙН АМЬДРАЛ
- ХОТЫН АМЬДРАЛ
- ОРОН НУТГИЙН АМЬДРАЛ
- УЛС ОРНЫ АМЬДРАЛ

НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

3

ЭРҮҮЛ ХҮНС – ЭРҮҮЛ АМЬДРАЛ

26

ДААТГАГДСАН ЭРҮҮЛ АМЬДРАЛ

28

САЙН БОЛОВСРОЛ-САЙХАН АМЬДРАЛЫН ҮНДЭС

30

МОНГОЛЫН БАЯЛГИЙГ МОНГОЛ ХҮҮХДЭД

31

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ Ч ХӨГЖЛИЙН ТЭМҮҮЛЭЛТЭЙ
ИРГЭД

32

ӨРХ ТЭРГҮҮЛСЭН ЭМЭГТЭЙЧҮҮД

34

ШИНЭ ЗАСАГЛАЛ – АРД ТҮМНИЙ ЗАСАГЛАЛ

36

ГАДААД ХАРИЛЦААНЫ ШИНЭ ТОГТОЛЦОО

39

ДҮГНЭЛТ САЙХАН АМЬДРАЛ - ТАНЫ СОНГОЛТ

40

ХАВСРАЛТ 1

42

ХАВСРАЛТ2

44

НЭГ. АМЬДРАЛЫН ТУХАЙ ТОО БАРИМТУУД

Оршил

Яагаад ИЗНН-ын Мөрийн хөтөлбөрийг бид "АМЬДРАЛ" гэж нэрлэсэн бэ?

Яагаад энэ хэсэг макро эдийн засгийн, тэр болгон та бид сонирхоод байдаггүй ДНБ, улсын төсвийн орлого, зарлага мөнгөний нийлүүлэлт гэх мэт үзүүлэлтүүдээр биш, харин иргэн Таны амьдрах орчин, Таны эрүүл мэнд, боловсрол, Таны хоол хүнс, Таны амьдардаг хот, аймгийн байдал гэх мэт үзүүлэлтээр эхэлж байна?

Яагаад гэвэл эдгээр нь шинжлэх ухааны үндэслэлтэй судалгааны тоо, баримтууд бөгөөд цаашид хэрхэх талаар дүгнэлт, бодлого арга замыг тодорхойлох үндэс болж өгдөг.

Яагаад гэвэл иргэн Та болон Таны үр хүүхдийн эвдрээгүй, сүйтгэгдээгүй байгаль орчинд, эрүүл сайхан амьдрах жам ёсны эрхийг ДНБ, эсвэл хичнээн сая тонн нүүрс, зэс, алт гэх мэт хуурай үзүүлэлтээр хангахгүй юм.

Яагаад гэвэл Таны болон Танай гэр бүлийн сайхан амьдрал нь баг, сум хороод, аймаг хот, улмаар улс, үндэстний хөгжлийн суурь нь юм.

Тийм ч учраас ИЗНН Таны амьдралын, Таны амьдралд шууд хамааралтай тоо баримтууд дээр тулгуурлан "АМЬДРАЛ" мөрийн хөтөлбөрийн гол үндэслэл, нотолгоог боловсруулсан бөгөөд энэ нь улс төрийн бусад намуудын бодлогын бичиг баримтаас ялгарах онцлог болж өгч байгаа юм.

Тийм ч учраас ИЗНН-ын бодит амьдрал дээр суурилсан Мөрийн хөтөлбөр нь "Иргэдээрээ овоглосон, Иргэдийн төлөө, Иргэд хэрэгжүүлэх Мөрийн хөтөлбөр хэмээн нэрлэгдэж байгаа юм.

1.1. Байгаль орчны доройтол ба хүний хөгжил

- Байгаль орчны доройтолд орсон газар нутагт амьдарч буй хүн амын эзлэх хувийн жингээр Монгол улс Азид тэргүүлж байна. Ялангуяа Сүхбаатар, Дорноговь, Дундговь, Өвөрхангай, Хөвсгөл аймагт газрын доройтол 60%-д хүрч, маш хурдацтай ихэсч байна.
- Нэг хүнд ноогдох ашиглаж болохуйц усны нөөц Дорнод, Хэнтий, Орхон, Сүхбаатар, Өмнөговь зэрэг 7 аймгийн нутагт олон улсын стандарт хэмжээнээс доогуур байна.
- Хөдөөд нийт өрхийн 41% нь ариун цэвэр, эрүүл ахуйн хувьд баталгаагүй усны эх үүсвэр ашиглаж байгаагаас хүн ам эрүүл мэндийн эрсдэлд өртөн, уснаас шалтгаалсан өвчлөл нэмэгдэж байна.
- Ойн сан жил тутам ойн талбайн 5%-иар доройтож байна. Ялангуяа Орхон, Дорнод, Дархан-Уул, Архангай, Баян-Өлгий аймгийг онцлох шаардлагатай

- 1 сая хүн тутамд байгалийн гамшигт өртсөн хүний тоогоороо Монгол улс Свазиландын дараа дэлхийд 2-р байранд орж байна. Хувиар илэрхийлбэл 2000-2009 онд жилд дунджаар Монгол улсын хүн амын 12% нь (Свазиланд-15%,Хятад-9.6%, Тажикстан-10%) гамшигт өртсөн байна.
- Ядуурлын түвшин 2002-2008 онуудад 36.1-35.3% байсан бол 2010 онд 39,3% болж нэмэгдэв.
- Хамтын нөхөрлөлийн орнуудын эмзэг байдлын индексээр Монгол улс дэлхийн 112 орноос 20-т жагсаж байна.

1.2. Хотуудын эмзэг байдал

- 2000 онд хүн амын 56.3% нь хотод амьдарч байсан бол 2010 онд энэ тоо 63.3%-д хүрэв.
- УБ хотын 273 мянган өрхийн 168 мянга нь гэр хороололд амьдарч байна.
- УБ хотын 1 хүнд ноогдох усны нөөц 962 м3, хэрэглээний усны хэмжээ 135 м3 байгаа бөгөөд ДЭМБ-ын 2005 оны судалгаагаар УБ хотын ундрагын усны эх үүсвэрийн 67% нь ахуйн хэрэгцээнд ашиглахад тохиромжгүй, эрүүл ахуйн шаардлага хангадаггүй байна.
- Туул голын дээд эхийн экосистем алдагдаж, хамгаалалтын онц нөхцөл байдал үүсэв.
- 2010 оны байдлаар УБ хотын нийт өрхийн дөнгөж 41% нь сайжруулсан ариун цэврийн байгууламжтай нөхцөлд амьдарч байна.
- Хөдөөгийн өрхийн дөнгөж 35.8% нь төвийн эрчим хүчний үйлчилгээ авч байна.
- Улсын хэмжээнд эрэгтэйчүүдийн 11%, эмэгтэйчүүдийн 13 % нь архаг хууч өвчтэй, экологийн доройтлоос болсон өвчлөлийн хэмжээ эрс нэмэгдэж байна.
- 2010 оны байдлаар улсын хэмжээнд 41373 хүн халдварт өвчнөөр өвчилсний 21424 (51.8%) нь УБ-ын иргэд байна.
- 10 мянган хүнд ноогдох амьсгалын замын өвчлөлийн тохиолдол агаар дахь хүхэрлэг хий (CO_2), азотын давхар исэл (NO_2) болон тоосжилт (PM_{10}) зэрэгтэй шууд холбоотой ба CO_2 -ын гол эх үүсвэр нь машины угаар юм.
- Цахилгаан станцаас гарч буй 4 сая орчим тн дэгдэмхий үнс нь маш нарийн ширхэгтэй тоосонцорыг нэмэгдүүлж, радио идэвхит бодис, хортой хүнд металлуудыг өөртөө агуулж байна.

1.3. Уур амьсгалын өөрчлөлтийн хэтийн төлөв

- Ойрын 20 жилд (2011-2030) жилийн агаарын дундаж температур $-0.8 - 1^{\circ}\text{C}$ хэмээр нэмэгдэнэ.
- Ойрын хугацаанд өвлийн улиралд агаарын дундаж температур $0.2-0.7$ хэмээр, дунд хугацаанд $1.6-2.3$ хэмээр нэмэгдэнэ.

- Жилийн дундаж хур тунадасын хэмжээ ойрын хугацаанд бага зэрэг буюу 2-3%-иар, дунд хугацаанд 9%-иар нэмэгдэнэ. Энэ нь голцуу өвлийн улиралд тохиолдоно.

1.3.1. Эдийн засагт үзүүлэх нөлөө

- ХАА-н салбар одоогийн байдлаар ДНБ-ын 18.1%, нийт хөдөлмөр эрхлэлтийн 38.5% эзэлж байна. 2010 оны байдлаар 216574 малтай өрх, түүний дотор 160625 малчин өрх байна.
- Бэлчээрийн гарц багасч, нийт биомасс бууран, малын тоо толгой болон мал сүргийн хорогдол ихсэх хандлагатай байна.
- Усны нөөцийн бүтэц өөрчлөгдөж байна. Энэ нь хүнсний аюулгүй байдалд эрсдэл авчирч байна.
- Усны эх үүсвэрүүд хорогдоно.

1.3.2. Эрүүл мэндэд үзүүлэх нөлөө

- Одоогийн байдлаар нийт нас баралтын 2%-ийг халдварт болон паразитын гаралтай өвчин эзэлж байгаа ба энэ тоо цаашид өсөх хандлагатай.
- Зүрх судасны өвчлөл 1990 онд 10000 хүн тутамд 160 байсан бол 2008 онд 640 болсон байна.
- Монголын нүүдлийн соёл иргэншлийн язгуур өвд аюул нүүрлэж болзошгүй байна.

1.3.3. Биологийн төрөл зүйлийн хомсдол

- 2030 он гэхэд Монгол улсын нутаг дэвсгэрийн 30%-ийг хамгаалалтад авах үүрэг авсан ч энэ цаг хугацааг 2016 он болгож наашлуулах зайлшгүй байдал үүсч байна.
- “Уур амьсгалын дүрвэгсэд” – (climate refugee) гэсэн нэр Монгол улсад бодит байдал болж эхлэв. Малчид үүнд хамгийн түрүүнд өртөж эхлээд байна.

1.3.4. Хүлэмжийн хийн ялгарал

- Хүлэмжийн хийн нийт ялгаруулалт 2006 онд 18868 ггр-д хүрч, Монгол улс 185 орноос 96-р байрыг эзэлжээ. Улаанбаатар хотын нэг хүнд 13.5 тонн CO₂ ялгаруулалт ногдож байна.
- Монгол улсын ДНБ-ын нэг ам.долларт ногдох CO₂ ялгаруулалтын түвшин дэлхийн нүүрс олборлогч томоохон 10 орноос хамгийн их нь байна. “Уур амьсгалын мэдрэмж”-тэй хөгжлийн хэрэгцээ

- Уур амьсгалын өөрчлөлт Монгол улсын эмзэг байдлын үндсэн шалтгаан хэдийнээ болоод байна. Одоо л арга хэмжээ авахгүй бол оройтох аюул бодитой бий болсон байна.
- Баруун ба хойт зүгийн нутгийн зарим хэсэг, Хангай, Хэнтийн нуруу, томоохон голын сав газарт нутагладаг иргэдэд хур тунадас нэмэгдэх, үер усны аюулд дасан зохицоход, харин говийн болон зүүн өмнө зүгийн нутгийн иргэдэд усны хомсдол, хуурайшилтанд дасан зохицоход нь дэмжлэг үзүүлэх талаар төрийн бодлого онц шаардлагатай болж байна.
- Малчдын дунд баян, ядуугийн ялгаа нэмэгдэж, дундаж амьжиргаатай малчдын тоог нэмэгдүүлэх талаар төрийн бодлого үгүйлэгдэж байна.
- Ойн доройтлыг онцгой анхааралд авах шаардлагатай боллоо. Улсын хэмжээнд ойн нөөц жилд дунджаар 5% доройтно гэвэл нийт ой устаж үгүй болоход 20 жил л шаардагдана. Архангай 10 жил, Баян-Өлгий 15 жил, Хөвсгөл аймаг 30 жилийн дараа ойгүй болохоор байна.
- Уул уурхайд химийн аюултай бодис ашиглаж байгаагаас нөлөөлөл нь ноцтой болох магадлал өндөр байна. Албан бус уул уурхайд 2011 онд 70 мянга орчим хүн ажиллаж байна. Эмнэсти Интернэшнлийн судалгаагаар мөнгөн ус цианит натрийг 9 аймгийн 20 гаруй суманд их хэмжээгээр ашиглаж, орон нутгийн усан хангамжийг бохирдуулсан байна. Албан бус уул уурхай бүхий сумдад зориулсан тусгай хөтөлбөр боловсруулж, уул уурхайн бусад компаниудын хамтын хүчин чармайлтаар хэрэгжүүлэх, альтернатив буюу ажил эрхлэлтийн бусад хэлбэрүүдийг хөгжүүлэх санхүүгийн болон эрх зүйн орчин яаралтай бүрдүүлэх хэрэгтэй байна. Албан бус уул уурхай эрхэлж буй иргэд бол нийгмийн "орхидос" биш. Иймд тэдэнд зориулсан эрүүл мэндийн суурь үйлчилгээ, боловсрол, нийгмийн даатгалын цогц арга хэмжээг авах ёстой.
- УБ хотын агаарын бохирдлын өнөөгийн энэ түвшин үргэлжилсэн хэвээр байх нөхцөлд 15 сая тн CO_2 -г шингээхийн тулд 5.1 сая га талбайд шилмүүст ой тариалах хэрэгтэй болно. Өөрөөр хэлбэл, УБ хотод жил бүр хуримтлагдсан CO_2 -г шингээхийн тулд Богд Хан уулын байгалийн нөөцийг 76 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэхүйц газрыг бий болгох шаардлагатай.

1.4. Боловсрол

- УБ хотын ядуу өрхийн бага болон дундаас доош шатны сургуульд суралцаж буй хүүхэд 2.1 км зам туулж байж сургуульдаа очдог байна.
- Коллеж, их, дээд сургуулийн оюутнуудын дөнгөж 15 % нь нийт хүн амын 40%-ийг бүрдүүлж буй ядуу, орлого багатай хэсгийн төлөөлөл байдаг.

1.5. Эрүүл мэнд

- 7497 эмчээс 4565 нь УБ-д байгаа бөгөөд нэг эмчид ногдох өвчтний тоо хөдөөд 3 дахин их байна.

- Ядуу өрхүүд нэг хүнд ногдох сарын хэрэглээнийхээ 2%-ийг эрүүл мэндийн үйлчилгээнд, 5%-ийг боловсролын үйлчилгээнд зарцуулж байна.
- Төв, Сүхбаатар, Дорноговь аймгийн 6 суманд шүдний өвчлөл маш их байсан ба 5-6 насныхны 94% нь шүдний ямар нэг гажигтай байна.
- 1999 онд хар тамхинд донтсон 45 хүн бүртгэгдсэн бол 2011 онд энэ тоо 410 болж даруй 9 дахин нэмэгдсэн байна.
- 2010 онд УБ хотын 22 сургууль, 12 их, дээд сургуулийн 2000 оюутан, сурагчдыг хамруулсан судалгаа хийхэд архи хэрэглэдэг 892, тамхи 809, бензин, цавуу үнэрлэдэг 52, экстаци 18, каннасис татдаг 36 оюутан байв.

1.6. Шүүн таслах ажиллагаа ба гэмт хэрэг

- 2011 онд улсын хэмжээнд 19197 гэмт гарсан. Гэмт хэргийн бүтцийн хувьд нийслэлд 56.1, орон нутагт 42.9 хувь нь гарчээ.
- Нийт гэмт хэргийн 22.5 хувь нь согтуугаар үйлдэгджээ.
- 18 ба түүнээс дээш насны 10 мянган хүн тутамд улсын дунджаар 104 гэмт хэрэг ногдож байна.
- Гэмт хэрэгт 17982 хүн холбогдон шалгагдсан бөгөөд эдгээрийн 12.8 хувь нь эмэгтэй, 6.5 хувь нь хүүхэд, 63.2 хувь нь 18-34 насны залуус, 56.1 хувь нь тодорхой эрхэлсэн ажилгүй, 5.5 хувийг урьд ял шийтгэгдсэн хүмүүс эзэлж байна. Гэмт хэргийн улмаас 922 хүн нас барж, 8100 хүн гэмтсэн байгаа.
- Хоногт улсын хэмжээнд 53, нийслэлд 30 гэмт хэрэг бүртгэгддэг. Улмаар хоногт дунжаар гэмт хэргийн улмаас гурван хүн нас барж, 22 хүн гэмтэж байна.

1.7. Авлига

- Олон улсын "Транспарэнси интернэшнл" байгууллагаас явуулдаг авлигын төсөөллийн индексийн судалгаагаар Монгол Улс 2.7 гэсэн үнэлгээтэйгээр дэлхийн 182 орноос 120-т орсон байна.
- 2011 онд хийсэн судалгаагаар Монгол Улсад авлига түгээмэл үзэгдэл болсон гэж нийт иргэдийн 81.4 хувь нь үзэж байна.
- 2009 онд хоёр болон түүнээс дээш давтан үйлдэлтэй авлигын гэмт хэрэг нийт гэмт хэрэгт 30.0 хувийг эзэлж байсан бол 2011 онд 51.0 хувь болж нэмэгдсэн байна.
- Авлигын гэмт хэргийн давталт буюу үйлдлийн тоо нэмэгдэж байгаа нь төрийн байгууллагын дүрэм журмын гажуудал, үйл ажиллагааны ил тод бус байдал нь эдгээр хэргийг дахин давтан үйлдэгдэхэд хүргэж байна.
- Зохион байгуулалттай гэмт хэргийн эзлэх хувь 2009 онд 42 хувь байснаа 2011 онд 58 хувь болж 16 пунктээр нэмэгдсэн нь авлигын гэмт хэргийг илүү зохион байгуулалттайгаар үйлдэх болсныг харуулж байна.

1.8. Байгаль орчинтой холбогдсон орлого, зарлага

Байгаль орчны орлого, зарлагын тэнцэл буюу бид байгалиас юу авч, байгальд юу өгч байгаа талаар статистикийн албан ёсны мэдээ одоогоор байхгүй байна. Монгол улсын тогтвортой хөгжлийн номлол, үзэл баримтлал, бодлогыг боловсруулахад энэхүү тоо баримт, түүн дээр тулгуурласан эрсдлийн дүн шинжилгээ нэн чухал шаардлагатай юм.

Дүгнэлт

Дээр дурдагдсан хүний хөгжил, байгаль орчны эмзэг байдалтай холбогдсон бүх статистик тоо баримтад тулгуурлан дараах гол дүгнэлтүүд, цаашид зайлшгүй хэрэгжүүлэх чиглэлүүд гарч байна. Үүнд:

Хөгжлийн бодлогодоо яаралтай засвар оруулж “даацтай буюу хөгжлийн” бодлого руу амаар биш ажил хэргээр орох цаг нэгэнт тулж ирсэн байна. Цаг хугацааны хувьд 2012-2016 он даацтай, хүмүүсийн оролцоотой тэнцвэртэй хөгжлийн бодлогын гарааны жилүүд болох ёстой.

Байгаль орчин, хүний хөгжлийн эмзэг байдлыг лавшруулж буй өнөөгийн хөгжлийн бодлогын чиг хандлага-“эрдэс баялгаа эрчимтэй ашиглаад түүнээс орж ирсэн орлогоор хүнээ хөгжүүлье, эдийн засгийн бусад салбаруудаа хөгжүүлье” гэсэн утгатай бодлого нь цаашид явцгүй, “хөгжлийн төөрөгдөлд” оруулж байна. Үүнээс ангижрахын тулд хүрэн эдийн засгаас ногоон эдийн засагт шилжих шилжилтийг үндэсний хэмжээнд эхлүүлж, бүс нутаг, аймаг, сумдын ялангуяа УБ хотын даацтай хөгжлийн бодлогыг иргэдийн өргөн оролцоотойгоор боловсруулан, 2013 оноос яаралтай хэрэгжүүлж эхлэх гарцаагүй шаардлагатай байна.

Байгаль орчны доройтол, эмзэг байдлын өнөөгийн түгшүүртэй байдал цаашид зогсолтгүйгээр, хурдацтай муудах магадлал маш өндөр байна. Эдгээр нь зөвхөн уул уурхай бус бусад маш олон хүчин зүйлийн нөлөөтэй байгааг харгалзан “уур амьсгалын өөрчлөлтийн өндөр” мэдрэмжтэй төрийн бодлого боловсруулах цаг тулж ирсэн байна.

Албан ёсоор гурван хүн тутмын нэг нь ядуу гэдэг ч ядуурах магадлалтай эмзэг хэсгийг тооцвол 50% илүү гарах нийгмийн том архагшсан өвчин болсон ядууралд хандах төрийн бодлогыг өөрчлөх цаг болсон байна. Ядуурал нь зөвхөн орлогын ядуурал бус олон хүчин зүйлээс хамаарсан олон хэмжээстэй ядуурал, тухайлбал, байгаль орчны эмзэг байдал, доройтол, эрүүл мэндийн суурь үйлчилгээний хүрэлцээгүй байдал, “ядуусын” өвчлөл /хоол хүнс, илчлэг, чанар гэх

мэт/, боловсролын хүртээмж чанар, эрчим хүч, ариун цэврийн байгууламж, амьдралын тухтай орчин, дэд бүтэц гэх мэтээс хамаарсан ядуурал болон хувирсан байна. Гэтэл үүнийг 21 мянган төгрөг, бусад нийгмийн халамж, хувьцааг эзэмшигч болгох гэх мэт байдлаар шийдвэрлэхгүй нь тов тодорхой байна.

"Хөгжлийн төөрөгдөлд" орсон Монгол улсыг хөгжлийн зөв замд нь оруулах ганц л гарц бий. Энэ нь хөгжлийн бодлого "даацтай, оролцоотой, тэнцвэртэй" гэсэн хүн төрөлхтөн яг одоо эрчимтэйгээр хэрэгжүүлж буй 3 үгийн агуулгаар баяжуулж Монгол хүн Монголдоо сайхан амьдрах тухай ИЗНН-ын мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлснээр биелэлээ олно.



ХОЁР. ИРГЭДЭЭР ОВОГЛОСОН, ИРГЭДИЙН ТӨЛӨӨ, ИРГЭД НЬ ХЭРЭГЖҮҮЛЭХ "АМЬДРАЛ" МӨРИЙН ХӨТӨЛБӨР

ИЗНН нь ардчилал, хүний эрх, эрх чөлөө, шударга ёсыг дээдлэн, байгальтай харьцах үндэсний уламжлалт сэтгэлгээ, хандлагаа эрхэмлэн хөгжүүлэгч, хувийн өмчид суурилсан тогтвортой эдийн засаг, ногоон хөгжлийг тэргүүлэх бодлогоо болгон тууштай хэрэгжүүлэгч, нийгмийг шинэчлэгч нам мөн.

Бидний эрхэм зорилго : Ардчилал, эрх чөлөөний үзэл санаанд тулгуурлан, экологийн чиг баримжаатай нийгэм-эдийн засгийн тогтвортой хөгжлийн замд улс орноо хөтөлж, хүн бүр өөрийн хүсэл эрмэлзлэлээрээ, шударга хөдөлмөрийнхөө үрээр Монголдоо сайхан амьдрах боломжийг бүрдүүлнэ.

Хүн-байгалийн хүн холбоо, арга билгийн шүтэлцээт харилцаанд тулгуурласан уламжлалт ухаанаар сэтгэдэг, байгалийн баялгийг өөрсдийн мэдэл, оролцоотойгоор, мэдлэгт суурилсан, амьдрах орчинд халгүй аргаар ашиглах замаар амьдралынхаа хэрэгцээг хангаж чадах **МОНГОЛ ХҮН**, Монгол-Ногоон соёл иргэншилд бид итгэдэг.

МОНГОЛ-НОГООН СОЁЛ ИРГЭНШИЛ нь экологи, улс төр, соёл, эдийн засаг болон нийгмийн асуудлаас бүрдсэн хоорондоо харилцан хамааралтай дэд тогтолцоо бүхий хувь хүн төвтэй хөгжлийн гарцын бодлого юм.

Хуучин намууд бэлэн мөнгө цацах богино настай бодлого явуулж, ард олныг улам ядуу дорой, бэлэнчилэх, төрийн гар харах, гуйланчилах сэтгэлгээнд оруулсан буюу оруулсаар байгаа бөгөөд биднийг байнгын ядуу байлгах гэсэн атгаг бодол өвөрлөж төрийн хөрөнгөөр тоглож байна. Бид Монгол хүнд ажил хийснийх нь төлөө амьжиргаатай байлгах цалинг нь олгох замаар ард түмний аж амьдралыг дээшлүүлэх, эрүүл бодлого баримтлана.

Бидэнд хэдэн үеэрээ ядуу байж хүлээх боломж байхгүй, бидэнд тийм цаг байхгүй, бидэнд тийм тэнхээ алга. Бид бүгдээрээ одоо хамтдаа, зоригтой өөрчлөлтийг эргэлт буцалтгүй хийж байж амжилтад хүрнэ.

Иргэний Зориг Ногоон Нам нь дэвшилтэт үзэлтэй олон мянган шударга иргэдийг нэгтгэж экологи, улс төр, соёл, эдийн засаг болон нийгмийн хөгжлийн өнөөгийн дүр төрхийг дүгнэн улс орныхоо хөгжлийг хурдасгах өргөн хүрээтэй зоримог алхмуудыг санал болгож байна.

Хувь хүний АМЬДРАЛ

Хувь хүний эрх, эрх чөлөө нь бусдын эрх чөлөөгөөр төдийгүй байгаль дэлхийн оршин байх эрхээр хязгаарлагдана.

- Нас, хүйс, шашин шүтлэг, намын харъяалал, угсаа гарал, оршин амьдарч буй газрын байршил, бэлгийн чиг баримжаа, нийгмийн байр сууриас үл хамааран хүн бүр эрхэм чанараа мэдрэн, айх аюулгүй, эрх чөлөөтэй амьдран, сурч боловсорч, амьдралаа өөрөө зохиож, аз жаргалаа эрэлхийлэх тэгш боломж олгохыг бид зорино.
- ИЗНН иргэдийнхээ эрх чөлөөт, элбэг хангалуун, дутагдал гачигдалгүй амьдрах эрхийг хангана.
- Залуучууд болон 45-аас дээш насны иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх замаар ажилгүйдлийг 50% бууруулна. Нас, хүйс, зүс царайгаар ялгаварлан гадуурхахыг зогсоож, 35-аас дээш насны иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тусгай хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд амьдралаа өөрчлөх бодитой дэмжлэг үзүүлнэ.
- Нийгмийн даатгалын шимтгэлийг нөхөн төлөх боломжийг бүрдүүлэх замаар хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг нийгмийн даатгалд хамруулна.
- Бэлэн мөнгө хавтгайруулан тараадгийг зогсоож халамж зайлшгүй шаардлагатай ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн амьдралын түвшинг өнөөгийнхөөс хоёр дахин нэмэгдүүлнэ.

Өрх гэрийн АМЬДРАЛ

- Хүүхдийн сүүний газар, сувиллын эмнэлэгүүдийг хот, хөдөөд хувийн хэвшлийн хувь оролцоотойгоор байгуулна.
- Хүүхэд, залуучуудын хөгжих орчин нөхцлийг бүрдүүлэх зорилгоор спортын ордон, клубууд, урлаг соёлын газрууд, судалгаа шинжилгээ, танин мэдэхүйн үйл ажиллагаа явуулах ордон, лаборатори байгуулах ажлыг төрөөс болон хувийн хэвшлийн хувь оролцоотойгоор байгуулна.
- Залуу эцэг эхийн, хүүхдийн боловсрол хүмүүжлийн талаарх сурган хүмүүжүүлэх мэдлэг чадварыг дээшлүүлэх ажлыг зохион байгуулж буй хувийн хэвшил, ИНБ-ын үйл ажиллагааг дэмжинэ.

- Төрөөс, өрхүүд сайн дураараа нэгдэн “хуримтлалын бүлэг” байгуулах, дундын буухиа зээлийн сан, бичил болон өрхийн бизнес эрхлэгчдэд шаардлагатай санхүүжилтийн бусад бүтцүүд байгуулахыг бүх талаар дэмжиж “Иргэний хөгжлийн зээлийн сан”-тай холбож иргэдийн оролцоог зээл сонгон шалгаруулах, хэрэгжилт, хяналт-мониторинг хийх зэрэг бүх шатанд бүрэн хангана.

Хотын АМЬДРАЛ

- Улаанбаатар, бусад томоохон хотуудын агаарын бохирдлын асуудлыг цогцоор шийдвэрлэнэ.
- Автозамын түгжрэл түүнээс үүдсэн хүндрэлийг саяаас дээш хүн амтай хотуудад авч хэрэгжүүлсэн үр дүнтэй арга хэлбэрээр шийдвэрлэнэ.
- Улаанбаатар хотын метроны зураг төслийг бэлэн болгоно.
- Хүүхдийн цэцэрлэг, сургуулийн хүрэлцээг эрс нэмэгдүүлэх, шинээр баригдаж буй орон сууцны хорооллуудад хүүхдийн цэцэрлэг, сургуулийг барих, тэдэнд ээлтэй орчин бүрдүүлэх бодлогыг дэмжинэ.
- Улаанбаатар хотыг ногооруулах 1 сая мод хөтөлбөр хэрэгжүүлнэ. Хотын иргэн бүр өөрийн модтой болно.

Орон нутгийн АМЬДРАЛ

- Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хуулинд өөрчилт оруулан, орон нутгийн төсөв, санхүүгийн эрх мэдлийг нэмэгдүүлнэ.
- Сумын засаг даргыг иргэд шууд сонгодог тогтолцоог бий болгоно.
- Аймаг, бүсийн хөгжлийн 2013-2020 оны хөтөлбөрийг батална. Зөвхөн цаасан дээр л үлддэг урьд өмнөх хөтөлбөрүүдийн хувь заяаг давтахгүйн тулд 5 бүсийн хөгжлийн асуудал хариуцсан захирагч нарыг сайдын зэрэглэлтэй тэнцэхүйц эрх мэдлээр хангаж ажиллуулна.
- Уул уурхайн салбараас олох орлогын 40 хүртэл хувийг тухайн орон нутгийн хөгжилд зарцуулдаг хууль эрх зүйн орчинг бүрдүүлнэ.
- Газар ашиглалтын орон нутгийн бодлогыг төрийн хэмжээнд нэгтгэж бэлчээрийн, газар тариалангийн, байгалийн нөөц ашиглалтын газруудыг нэгдсэн системээр зохицуулна.
- Гадаад худалдаа, түүний дотор хил худалдааг аймаг, бүс нутгийн хөгжлийн нэг гол хөшүүрэг гэж үзэн худалдаа, тээврийн нөхцлийг хөнгөвчлөх, хилийн боомтуудыг үйл ажиллагааг бизнес эрхлэгчдэд таатайгаар хөгжүүлснээр ажлын байрыг нэмэгдүүлэх, худалдааг дэмжсэн чухал алхам болно.

- Зах зээлийн мэдрэмжтэй, хөрвөх чадвар сайтай, зохистой сүргийн бүтэц бүхий малчдын бүлгийг төрийн бодлогоор дэмжих, малжуулах зээлийг төр-арилжааны банкны хамтын ажиллагаанд түшиглэн хэрэгжүүлж, зээлийн дарамтнаас малчдыг чөлөөлөх боломжийг бүрдүүлнэ.
- Малын бэлчээрийг хамгаалах бодлого боловсруулж хэрэгжүүлнэ.
- Алслагдсан сумдын соргог бэлчээрийг худаг усаар хангана.
- Сумдын иргэдийн мэдээлэл, харилцаа холбоог сайжруулна.
- Малын хулгай, гэмт халдлагаас хамгаалах хуулийг чангатгана.
- "Цагаан алт" болох ноосыг боловсруулах, жижиг дунд үйлдвэрийг дэмжинэ.
- Сумын төвийн ажилгүй иргэдийг ажлын байртай болгох, ажил үйлчилгээ эрхлэх жижиг оврын тоног төхөөрөмжөөр хангах ажлыг зохион байгуулна.
- Малын үүлдэр угсааг сайжруулахад онцгой анхаарна.
- Сүү, цагаан идээг боловсруулах, малчид хоршоо нөхөрлөл байгуулах, жимс, ногоо тарьж боловсруулах санаачлагыг төрийн бодлогоор дэмжинэ.
- Эмийн ховор ургамалыг орон нутгийн иргэдийн хамгаалалтанд өгнө.
- Эхчүүд сумандаа төрөх нөхцлийг бүрдүүлнэ.

Улс, орны АМЬДРАЛ

1. Ногоон хөгжлийн бодлого

ИЗНН эдийн засгийн өсөлт, хөгжлийн даацтай /1/, тэнцвэртэй, оролцоотой" /2/ загварыг мөрийн хөтөлбөрийнхөө гол бодлогын томъёолол болгон зарлаж байна. Энгийн үгээр томъёолбол,

1.1. Даацтай өсөлт, хөгжил

Юу?



Дэлхийн улс орнууд даацтай¹ өсөлт хөгжлийн талаар дор хаяж 22 жилийн өмнөөс ярьж эхлээд, бодитой үйл ажиллагаанууд авч хэрэгжүүлсээр байна. Гэвч Монгол улсын хувьд даацтай хөгжлийн бодлого тодорхой биш, хийгдсэн ажлууд эхлэлийн төдий байна. Даацтай өсөлт, хөгжил гэж тэгвэл чухам юу вэ? Эдийн засгийн чиглэлээр олон бүтээн байгуулалт, үйл ажиллагааг байгаль орчин нь даахгүй болоод дээр нь цөлжилт, бэлчээрийн доройтол, агаарын бохирдол, хөрсний эвдрэл, усны дутагдал, ойн доройтол гэх мэт үйл явц эрс мэдрэгдээд ирэх энэ үед л байгальтайгаа зохицож амьдрах, эдийн засаг нь байгаль орчиндоо тулгадаг биш байгаль орчин нь эдийн засагтаа тулгадаг тийм л цаг үед л даацтай өсөлт, хөгжлийн бодлогыг сонгохоос өөр аргагүй байдалд Монгол улс орчихоод байна. Бид өвөг дээдсээс өвлөгдөн ирсэн байгалийн баялгаа үе үеийн монголчуудын амьдралыг дээшлүүлэхэд зориулахдаа эдийн засгийн үр ашгаас экологийн эрх ашгийг дээгүүр тавьж, Монголын эдийн засгийн уламжлалт салбаруудыг хөгжүүлэн, өрсөлдөх чадвартай, өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэхийн зэрэгцээ орчин үеийн өндөр технологийн салбарыг хөгжүүлэх замаар олон тулгуурт эдийн засгийн бүтцийг бий болгоно.

Даацтай өсөлт хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх гол арга зам нь эдийн засаг, бизнес, нийгмийн сэтгэлгээг “ногооруулах” явдал юм. Гэтэл улс төрийн намуудын үзэл баримтлал, мөрийн хөтөлбөрүүдэд энэ талаар ерөнхий зүйлүүд л тусгагдаж их төлөв тунхаглалууд бичигдсэн байна. 2031 онд нэг хүнд оногдох ДНБ-ний түвшин тийм болно, 2020 онд Монгол хүнээ ингэж хөгжүүлнэ, чинээлэг болгоно гэх мэтээр ярьж бичиж болох хэдий ч хүний амьдрах орчны талаар санаа зовж, цаг алдалгүй, яаралтай, шийдэмгий алхмууд хийх ёстой гэж ИЗНН үзэж байна.

Яаж? Хэзээ? Хэн?

- “Ногоон соёл иргэншил” гэсэн төрийн бодлогыг тодорхойлж хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.
- **Даацтай хөгжил, байгаль орчны асуудал** бол Монгол улсын **хөгжлийн тэргүүлэх чиглэл № 1** гэдгийг Монгол улс Үндсэн хуульд суулган, дэлхий даяар, НҮБ ба олон улсын бүх байгууллагуудад, улс орнуудад зарлан тунхаглах. Энэ бол урьд өмнө дэлхийд гарч байгаагүй санаачилга бөгөөд Монгол улсын энэ санаачилга маш их дэмжлэг авна.
- Байгаль орчин, эрдэс баялгийн болон үндэсний хөгжил, шинэчлэлийн асуудал хариуцсан яамд, хороог нэгтгэн **“Даацтай хөгжлийн төлөвлөлт, зохицуулалтын Яам”**-ыг үндсэн чиг үүргийн гол институт болгон байгуулна. Тус бүтэц бүрдсэнээр байгалийн нөөцийн асуудлыг хэрэгжүүлж буй байгууллагуудын чиг үүрэг уялдан, хамтын ажиллагаа, бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагаа сайжран, байгаль орчны хууль тогтоомжуудын хэрэгжилт сайжирна. Байгалийн нөөцийн ашиглалт, хамгаалалт, нөхөн

¹ Sustainable development гэдгийг Монгол улсад албан ёсоор “тогтвортой хөгжил” гэж орчуулдаг хэдий ч энэ нь агуулгын болон нэр томъёоны хувьд бүрэн илэрхийлэгдэж чадахгүй байгаа тул Ерөнхийсайд асан Д.Бямбасүрэнгийн “даацтай” гэсэн томъёоллыг авч хэрэглэв.

сэргээлтийн үйл ажиллагаа МОНГОЛ НОГООН СОЁЛ ИРГЭНШИЛ
ХӨГЖИЛИЙН бодлоготой уялдуулан хэрэгжинэ.

- Нутгийн иргэд өөрөө удирдах байгууллагатайгаа хамтран орон нутгийнхаа онцлогийг харгалзсан хамгаалалт, тогтвортой ашиглалтын бүс бүслүүрийг мэргэжлийн байгууллагын судалгаа, дүгнэлт үндэслэн өөрсдөө тогтоон, нутаг орныхоо жинхэнэ эзэд нь болно.

Тодруулбал:

- 2020 он хүртэлх хугацаанд байгаль орчинд оруулах хөрөнгө оруулалтыг нийт хөрөнгө оруулалтын 20%-д хүргэнэ,
- Эрчим хүчний үр ашгийг 2020 он гэхэд 20 хувиар дээшлүүлнэ²,
- Сэргээгдэх эрчим хүчний суурилагдсан хүчин чадлыг өнөөгийн байдлаар 4,3% байгааг эрс нэмэгдүүлэх бодлого хэрэгжүүлж 2020 он гэхэд 20 %-д хүргэнэ.³
- Монгол улсын нутаг дэвсгэрт цөмийн цахилгаан станц барих, цөмийн түлш үйлдвэрлэх, цөмийн хаягдлыг байршуулахыг хатуу хориглоно
- Засгийн газрын худалдан авалтын буюу бидний нэрлэж заншсанаар тендерийг шударга болгохоос гадна "ногооруулж"⁴, 2013 оноос эхлэн Засгийн газрын худалдан авалтанд "ногоон худалдан авалт"-ыг тусгайлан оруулж, 2020 он гэхэд 20 хувь болгоно.
- 2020 он гэхэд хүлэмжийн хийн ялгаруулалтыг 20% багасгах, энэ чиглэлээр уур амьсгалын мэдрэмжтэй хөгжлийн бодлогыг УБ хотод, бүс нутаг, аймгуудын даацтай хөгжлийн бодлогод тусгаж өгнө /2013-2016/
- Ногоон бизнесийг тэргүүн ээлжинд урамшуулах татвар, гааль, хөрөнгө оруулалтын сэдэл санаа, сэжим түлхэцийн иж бүрэн арга хэмжээг 2013 оноос яаралтай хэрэгжүүлж эхлэнэ⁵.
- Аймаг бүсийн даацтай хөгжлийн 2013-2020 оны хөтөлбөрийг батлах, гэхдээ энэ нь цаасан дээр л үлддэг урьд өмнөх хөтөлбөрүүдийн хувь

² Монгол улсын 1 ам.доллартай тэнцэх бүтээгдэхүүн үйлдвэрлэхдээ зарцуулж буй эрчим хүчний хэмжээ дэлхийн болон Европын дунджаас ихээхэн дээгүүр байна.

³ Нар, салхины эрчим хүч, газрын гүний дулаан ашиглах хувийн хэвшлийн санаачилга байгаа хэдий ч төрөөс дэмжих бодлого цаасан дээр л байна.

⁴ Төсвийн хөрөнгөөр барьж буй барилга объект, зам, дэд бүтэц гэх мэт нь байгаль орчны ямар ч шалгуур, үнэлэмж, үр ашгийн үзүүлэлт байхгүй байна.

⁵ Туулын усыг бохирдуулж, элс хайргыг нь зөөж бизнес хийх, усыг эргүүлэн ашиглаж энэ чиглэлээр хөрөнгө оруулалт хийж буй компаниудын хувьд зарчмын ямар ч ялгаа байхгүй, харин ч ногоон бизнесийн санаачилга гаргаж буй хэсэг нь өртөг зардал гэх мэтээр хохироход хүрч өрсөлдөх чадварт нь нөлөөлж байна.

заяаг давтахгүйн тулд 5 бүсийн даацтай хөгжлийн асуудал хариуцсан захирагч нарыг сайдын зэрэглэлтэй тэнцэхүйц эрх мэдлээр хангаж өгнө.⁶

- Байгалийн нөөцийн даацтай ашиглалт, хамгаалалтыг сайжруулах үүднээс орон нутгийн иргэдэд тулгуурласан, байгалийн нөөцийн удирдлагын эрхийг тэдэнд өгсөн үзэл баримтлалыг нэвтрүүлэх⁷: (i) байгалийн баялгийг хамгаалагч, ашиглагч, эзэмшигчид нь үйл ажиллагаагаа нутгийн өөрөө удирдах байгууллагад тайлагнадаг, цаашдын үйл ажиллагааг хамтран шийддэг тогтолцоонд шилжинэ, (ii) байгалийн тодорхой төрлийн баялгийг хариуцан хамгаалах, ашиглах, эзэмших иргэдийн бүлэг, нөхөрлөлийн үйл ажиллагааг дэмжэн нутагтаа байгалиа хамгаалах, амьжиргаагаа дээшлүүлэх, бие биедээ туслах, хамтран ажиллах зорилготой нэг нутаг усны айл өрхүүдийн нөхөрлөл жинхэнэ утгаараа байгуулагдах үйл явцыг дэмжинэ, (iii) байгаль хамгаалах, бэлчээр ашиглагчдын болон ойн нөхөрлөлүүдийг дэмжих ажлыг эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгосноор дэмжих, орлого нэмэгдүүлэх боломжийг өргөтгөн, орон нутагт ажлын байр бий болгоно.
- Ашигт малтмалын хайгуулын лиценз олгохдоо орон нутгийн байгалийн нөөцийн судалгаа, тооцоо, менежментийн төлөвлөгөөг үндэслэж түүнтэй уялдуулан олгож байх тогтолцоо бий болгон, энэ ажилд Нутгийн өөрөө удирдах байгууллага тэргүүлэх үүрэг, эрхтэй оролцох нөхцөл бүрдүүлнэ.
- Ашигт малтмалын тухай хуулинд ашиглалтын лиценз олгохдоо орон нутаг дахь түүх соёлын дурсгалт газрыг хамгаалах шаардлагыг харгалзан үзэх, тухайн газарт түүх, археологийн мэргэжлийн байгууллагаар урьдчилан судалгаа хийлгэж дүгнэлт гаргуулах, илэрсэн түүх соёлын дурсгалт зүйлийг хамгаалах ажилд шаардагдах зардлыг тухайн аж ахуйн нэгжээр төлүүлэн эрх зүйн үндэстэй болно.
- Эрдэс баялгийн салбарын нийгэм-байгаль орчны нөлөөлөл, нөөц ашиглалт, нөхөн сэргээлт, техник технологийн стандартуудыг шинэчлэхдээ өндөр хөгжилтэй орнуудын стандарт, техник технологийн шинжлэх ухааны үндэслэлтэй өөрийн хөрсөн дээр буулгаж шилжүүлнэ. Чингэхдээ өөрийн эх нутагт хүчин төгөлдөр хэрэгжигдэж буй холбогдох бүх стандартыг Монгол улсад ч бүрэн хэрэгжүүлэхийг гадаадын хөрөнгө оруулагчдаас шаардах зарчим баримтлана.
- “Хаягдсан талбайг нөхөн сэргээх санаачлага” төслийг эхлүүлж эдгээр талбайн нөхөн сэргээлтийг мэргэжлийн өндөр төвшинд хийх санхүүжилтийг уул уурхайгаас олж буй орлогоос болон хувийн хэвшилтэй хамтран хэрэгжүүлэх механизмыг бий болгох – 2014

⁶ Ийм хандлагаар байгаль орчин, даацтай хөгжлийн асуудалд хандахгүй бол 5-10 жилийн дараа Монгол орны байгаль орчны доройтол хэзээ ч дахин эргэж сэргэхгүй байдалд орох аюултайг судалгааны үр дүн нотолсоор байна.

⁷ Тогтоол, шийдвэр дээрээсээ биш, иргэдийн оролцоонд тулгуурласан, сум орон нутгийн онцлогт тохирсон байх нөхцөл бүрдэнэ.

- Монгол улс, орон нутгийн хөгжлийн үндсэн чиглэл, төлөвлөгөөтэй уялдуулан нийт Монгол улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд газар ашиглалтын бодлогыг боловсруулана
- Газрын гадаргын болон хэвлийн ашиглалтын зөрчлийг арилгахын тулд бүс нутгийн болон улсын газар ашиглалтын бодлогыг тодорхой болгож, ашигт малтмалын хайгуул, олборлолт явуулж болох талбайг хязгаарлана.
- Аж үйлдвэр металлургийн салбарыг дэмжиж эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэхийг эрчимжүүлэх – 2014 онд багтаан үндэсний хүнд үйлдвэрийн хөгжлийн хөтөлбөрийг боловсруулж бүсүүдэд ач холбогдол бүхий аж үйлдвэрлэл, ашигт малтмал дээр суурилсан металлургийн үйлдвэрлэлийг дэмжих, олон улсын зах зээлд үндэсний үйлдвэрлэлийн бүтээгдхүүнийг гаргах нөхцөл бололцоог буй болгоно.
- Уул уурхайн салбарын ханган нийлүүлэлт, үйлчилгээний салбарт үндэсний жижиг, дунд үйлдвэрлэлийг хууль эрхзүйн бодлого, уян хатан санхүүжилтын эх үүсвэрээр дэмжиж Монголчууддаа бололцоог нээж өгөх болон нийлүүлэлтийн үйл ажиллагаанд дотоодын компаниудыг дэмжих бодлого баримтална
- Хүний хөгжлийн санг өөрчлөн байгуулах замаар Үндэсний Ирээдүйн Баялаг Санг бий болгоно. Энэхүү хөрөнгө оруулалтын сан нь бие даасан төр, нийгмийн оролцоотой удирдах зөвлөлтэй, мэргэжлийн хөрөнгө оруулалтын сангийн удирдлагатай, ашиг өгөөж олох, өсөлтийг хангах нөхцөлтэй, нээлттэй ил тод удирдлагатай байх бөгөөд орлогыг нийгэмд хэрэгтэй урт хугацааны, эдийн засгийн хувьд ашиг хуримтлуулах боломжтой төслүүдэд мэргэжлийн шалгууруудыг үндэслэн хөрөнгө оруулалт хийх үүрэг хүлээх юм.⁸

1.2. Оролцоотой ба тэнцвэртэй өсөлт

Юу?

⁸ Эдийн засгийг төрөлжүүлэх үүднээс уул уурхайн салбараас олж буй ашгийг уул уурхайгаас бусад нийгэмд хор хөнөөлгүй (жишээ нь архи тамхи, байгаль орчинд хортой үйлдвэрлэлд болохгүй) салбарт хөрөнгө оруулах шаардлагатай ба өндөр эрсдэлтэй төсөл, салбар, үйлдвэр, аж ахуйн нэгжид хөрөнгө оруулахыг хориглох хууль эрхзүйн орчинг бүрдүүлнэ.

Эдийн засгийн хүнд нөхцөл, хямралын жилүүдэд, эсвэл орлогыг хөрөнгө оруулалтад оруулах боломжгүй цаг үед өөрт хуримтлагдсан ашиг орлогоос нийт иргэдэд мөнгөн орлого олгохыг зөвшөөрөх боловч энэ нь аливаа улс төрийн мөрийн хөтөлбөр, бодит бус амлалтыг хэрэгжүүлэх зорилгоор тараахыг зөвшөөрөхгүй юм.

Монголын ирээдүйд зориулсан санг төрийн, улс төрийн нөлөөллөөс холдуулсанаар байгалийн баялгаас олсон ашгийг өөрсдөө бурхан мэт олгож буй төр, улс төрийн хүчнээс ангид хариуцлагатай, ил тод иргэдийн оролцоотой хүртээлтэй байх нөхцөл бүрдэнэ.

Яагаад иргэд маань ДНБ 15%, 17 % гэх мэт өслөө, одоо цаашид ч өсөх нь, Монгол хүнд ноогдох хэмжээ нь одоо тэд боллоо, болно гэх мэт мэдээ, мэдэгдэлд ихэнх нь үнэмшдэггүй эсвэл бухимдангуй хүлээн авдаг вэ?

Яагаад иргэдийн маань ихэнх нь "тэгвэл яагаад миний амьдралд, манай гэр бүлийн амьдралд тэр чинь наалдахгүй байгаа юм?! " гэсэн жирийн амьдралын гаргалгаатай, зүй ёсны асуултыг төрд тавьдаг вэ?

Өнөө хүртэл аль ч улс төрийн нам, Засгийн газар хариултыг нь өгч чадаагүй, гаргалгааг нь хийгээгүй энэ 2 энгийн мөртлөө хэцүү асуултанд ИЗННам иргэн танд дараах байдлаар хариултыг өгч байна.

Яагаад гэвэл иргэн таны итгэл үнэмшлийг төрүүлэхгүй, уур уцаар, бухимдлыг чинь төрүүлээд байна гэдэг чинь тэр ДНБ гэж үзүүлэлт таны амьдралыг бодитойгоор хэмжин илэрхийлэхгүй байгаа л гэсэн үг. Тэгвэл таны, бидний амьдралыг бодитой хэмжиж чадахгүй байгаа тэр үзүүлэлтүүдээ өөрчилж, оронд нь та бидний амьдралын бодит байдал, чанарыг илэрхийлж чадах өөр үзүүлэлтүүдийг гаргаж хэрэглэ гэсэн үг юм. Дэлхийд өнөөдөр ДНБ, түүний нэг хүнд оногдох хэмжээ гэсэн үзүүлэлтийг хүний амьдралын хэмжүүр, тэр тусмаа амьдралын чанарыг хэмжих үзүүлэлт огт биш гэдгийг хүлээн зөвшөөрч хүний хөгжлийг тал бүрээс нь бодитой хэмжсэн үзүүлэлтүүдээр хэмждэг болж байна.

Хүмүүс эдийн засгийн өсөлтийн үр өгөөжийг мэдэрч чадахгүй байгаагийн гол шалтгаан нь эдийн засгийн өсөлтийг бий болгоход тэдний оролцоо хангалтгүй байгаа буюу эдийн засгийн оролцоотой өсөлтийн бодлого хэрэгжихгүй байгаатай шууд холбоотой. Өөрөөр хэлбэл, бидэнд 21 мянган төгрөг, иргэн бүрт 1072 хувьцааг эзэмшүүлэх замаар эдийн засгийн өсөлтийн үр өгөөжийг тэгш хуваарилж түүнийг шударга ёсны шалгуурт таарч тохирч байна гэсэн агуулгатай бодлого сүүлийн жилүүдэд хэрэгжиж түүнийг цаашдаа хэрэгжүүлэхийг зорих нь эдийн засгийн оролцоотой өсөлт биш бөгөөд эдийн засгийн оролцоотой өсөлтийн бүрэлдэхүүн хэсэг болох өсөлтийн хурдац /15 %, 20% гэх мэт/, өсөлтийн арга зам /яаж ямар аргаар энэ өсөлтийг хангав гэх мэт/ гэсэн 2 гол зүйлийг хооронд нь зохистой уялдуулсан нөхцөлд л оролцоотой өсөлт гарч ирнэ. Манай улсад уул уурхайн өсөлтөөр нөхцөлдсөн өсөлтийн өндөр хурдац нь бол байна харин өсөлтийн гол чанарын үзүүлэлт болох өсөлтийн арга зам нь ихэнх иргэдийн оролцоог хангаж чадахгүй байгаад л асуудлын гол нь оршиж байна.

Монголын нийгэмд орлогын тэгш бус хувиарлалт гэж нэрлэгддэг үйл явц сүүлийн жилүүдэд бодитойгоор явагдаж энэ нь өнөөдөр баян цөөнх, ядуу олонхи гэсэн эдийн засаг-нийгмийн, улс төрийн томоохон асуудлыг үүсгэж зөв бодлогоор энэ асуудлыг нухацтай шийдэхгүй бол цаашид нийгмийн хямралд ч хүргэж мэдэх аюултай түвшинд очихоор байна.

Тиймээс ИЗННамаас оролцоотой, тэнцвэртэй өсөлтийн бодлогыг энэхүү асуудлыг шийдвэрлэх гол арга зам гэж үзэж байна. Энгийн үгээр хэлбэл энэ нь дунд ангийг, нийгэмд баялаг бүтээгч, ажлын байр бий болгогч, нийгмийн үйлчилгээ үзүүлэгч дундаж амьжиргаатай хэсгийг баян, ядуугийн улам бүр өсөж буй зааг, ангиллыг багасгах, нийгмийн тогтвортой байдлын "зөөлөвч" болгоно гэсэн хэрэг юм.

Яаж? Хэзээ? Хэн?

- Дунд ангийг бүрэлдүүлэгч гол цөм болох бичил, жижиг, дунд бизнесийн үйл ажиллагааг татварын хууль эрх зүйн бодлогоор дэмжиж тэдний санхүүгийн болон бизнес эрхлэх орчинг тааламжтай болгох, Дэлхийн банкны бизнес эрхлэлтийн индекс, эдийн засгийн эрх чөлөө, өрсөлдөх чадвар гэх мэт олон улсын бүх индексүүд дээр тулгуурласан зорилтот хөтөлбөрийг боловсруулж 2013-2016 онд хувийн хэвшилтэй хамтран хэрэгжүүлэх.
- Бичил болон өрхийн бизнесийг зохицуулж буй өнөөгийн санхүүгийн механизм болон хууль эрх зүйн орчинг өөрчлөх
- Хот, аймаг, дүүрэг, сум, баг, хороо бүрт төрийн, иргэний болон хувийн хэвшлийн тэнцүү тооны төлөөлөл бүхий бичил болон өрхийн бизнесийн хөгжлийг дэмжих хороодыг байгуулж зөвхөн энэ бүтцээр дамжуулан санхүүжилтийн шийдвэр гаргаж байх тогтолцоог нэн түрүүнд бүрдүүлэх.
- Энэхүү бүтцээр дамжуулан банкны салбарууд, банк бус байгууллагууд болон иргэд болон өрхийн бизнесийн сайн дурын үндсэн дээр зохион байгуулагдсан зээлийн хоршоод, буухиа зээлийн сан гэх мэт үүсгэл санаачлагын байгууллагуудыг тэнцүү эрхтэйгээр шударгаар өрсөлдүүлсний үндсэн дээр зээлийг хувиарлаж хэрэгжүүлэх.
- Үндэсний хэмжээнд бичил болон өрхийн бизнесийг дэмжих "Иргэний хөгжлийн зээлийн сан" нь хүний хөгжлийн сангийн бүрэлдэхүүн хэсэг, гэхдээ өөрөө бие даан эдийн засгийн эргэлтэнд орох боломжтой байх ёстой бөгөөд энэ зориулалтаар Төрөөс эхлээд 100 тэрбум төгрөгийн санхүүжилт, энэ сантай шууд холбоотой "Иргэдийн зээлийн баталгааны сан"-нд 30 тэрбум төгрөг тус тус шаардлагатай.
- төрөөс, өрхүүд сайн дураараа нэгдэн "хуримтлалын бүлэг" байгуулах, дундын буухиа зээлийн сан, бичил болон өрхийн бизнес эрхлэгчдэд шаардлагатай санхүүжилтийн бусад бүтцүүд байгуулахыг бүх талаар дэмжиж "Иргэний хөгжлийн зээлийн сан"-тай холбож иргэдийн оролцоог зээл сонгон шалгаруулах, хэрэгжилт, хяналт-мониторинг хийх зэрэг бүх шатанд бүрэн хангах
- бичил, өрхийн болон жижиг бизнест шаардлагаай тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, авсаархан технологи гэх мэтийг иргэдэд санхүүгийн лизингээр олгох замаар өөртөө болон өрөөл бусдад ажлын байр бий болгон амьжиргаагаа дээшлүүлэх санхүүгийн орчинг 2013-2016 нд бий болгох, энэ чиглэлээр ажиллаж буй санхүүгийн лизингийн компаниудыг татвараас чөлөөлөх зэргээр эдийн засгийн сэжим түлхэцийн тогтолцоо бий болгох
- бичил болон өрхийн жижиг бизнес эрхэлж буй иргэдэд үйлдвэрлэл-үйлчилгээний зориулалтаар, төрөөс тогтоосон инкубаторын нөхцөлөөр ажлын байр, объектыг түрээсэлж буй аж ахуйн нэгжүүдийг дэмжин үл хөдлөх хөрөнгийн татвараас чөлөөлөх
- 2012-2016 онд аймаг, дүүрэг бүрд дор хаяж 1 инкубаторын төвийн барилга барих санхүүжилтийг төрөөс гаргаж инкубаторын төвүүдийн менежментийг иргэдийн мэдэлд өгөх

Бичил болон өрхийн бизнесийг дээрх байдлаар дэмжихийн сацуу жижиг, дунд бизнесийг дэмжиж буй өнөөгийн бодлого хэрэгжиж байгаа механизмыг өөрчлөнө. Үүнд:

- ЖДҮйлдвэрлэгч ба ЖДБизнес гэж 2 ялгааг тогтоож санхүүжилтийн механизмыг өөрчлөнө. Учир нь хэдийгээр үйлдвэрлэлийг дэмжих нь нэн тэргүүний ач холбогдолтой, үйлдвэржилтийн бодлогын гол чиглэл мөн хэдий ч үйлчилгээ, худалдаа гэх мэт салбарууд энэ бодлогын гадаа орхигдож байна. Гэтэл энэ салбаруудад мөн л адилхан ажлын байрууд бий болж мөн л адилхан өртөг, нэмэгдсэн өртөг бүтээгдэж байдаг.
- ЖДҮ-д олгож буй өнөөгийн санхүүжилтийн хувь хэмжээг нэмж жил бүр улсын төсөвт ЖДБизнесийг дэмжих зориулалтаар хамгийн багадаа 200 тэрбум төгрөг болгоно.
- Зээлийг олгож буй өнөөгийн механизмийг танил тал, нам, хамаатан садны сүлжээнээс ангижруулж, ЖДБизнесийнхэнд бодитой нэмэр болохуйц болгон шинэчлэнэ⁹.

Үндэсний том компаниудад хандсан төрийн бодлого, ялангуяа уул уурхайн бус үйл ажиллагаа эрхэлдэг үндэсний томоохон компаниудыг олон улсын хэмжээнд

⁹ Хэлбэр төдий хуурамч "төр-хувийн хэвшлийн түншлэл" гэвч энэ зээлийн олголтонд хэрэгжиж байна, өөрөөр хэлбэл, хувийн хэвшлийн төлөөллийн байгууллагаас 1-2 хүнийг ёс төдий оруулдаг, олонхи нь төрийн төлөөлөл байдаг зээлийн хороо ажиллаж байна. Тиймээс:

- зээлийн хороодын аль ч түвшний бүтцийг төр ба хувийн хэвшлийн тэнцүү тооны төлөөлөлөөс бүрэлдүүлэхийг хууль ёсны болгох
- ЖДҮ-ийн зээл эцсийн шатанд зөвхөн арилжааны банкинд шийдэгдэж буйг өөрчилж банк бус санхүүгийн байгууллагууд, хөрөнгө оруулалтын сан гэх мэт санхүүгийн зуучлагчдыг өргөнөөр оролцуулж өрсөлдөөний орчин үүсгэх
- уул уурхайн салбарт гадаад, дотоод хөрөнгө оруулалтын томоохон төслүүд ба орон нутгийн жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээг хооронд нь холбосон эрх зүйн болон санхүүжилтийн бүтцийг бий болгох замаар уул уурхай- ЖДБизнесийн кластер бий болгох.
- хувийн хэвшлийн төлөөллийн байгууллагууд, салбарын холбоодыг ЖДБизнесийг хөгжүүлэхэд идэвхтэй татан оролцуулж тэднээр дамжуулан ЖДБизнесийн зээл шууд олгох замаар альтернатив санхүүжилтийн бүтэц бий болгох
- ЖДҮ болон ЖДБизнесийг татварын бодлогоор дэмжих, ялангуяа НӨАТ-ийн босгыг 100-150 сая төгрөгийн хэмжээнд тогтоох, ЖДБизнесийн бүртгэл, ня-бо бүртгэл зэргийг хялбаршуулах, цахим хэлбэрт оруулах
- ЖДБизнесийн зээлийн баталгааны сангийн хөрөнгийн эх үүсвэрт төрийн зүгээс нэг удаагийн буцалтгүй санхүүжилт олгох, бусад эх үүсвэрийг санхүүгийн байгууллагууд, хөрөнгө оруулалт, хувийн тэтгэвэр гэх мэт сангууд бүрэлдүүлэх эрх зүйн болон сангийн менежментийн бие даасан бүтцийг бий болгох
- ЖДБизнесийн хувийн тэтгэврийн санг байгуулж эрх зүйн үндсийг яаралтай бүрдүүлэх, хувийн хэвшил, түүний төлөөллийн байгууллагуудын энэ талаарх санал санаачилгыг тал бүрээр дэмжих бодлого явуулж улсын ба хувийн тэтгэврийн сангууд шударга өрсөлдөх эрх зүйн болон бодлогын орчин бий болгох замаар шийдвэрэх.

гаргах, өрсөлдөх чадварыг нь дээшлүүлэх тусгай хөтөлбөр хэрэгжүүлж “Үндэсний манлай компаниудыг” төрүүлэх хөшүүргийг бий болгоно.

Төр ба зах зээлийн хоорондын зохистой харилцааг тогтоож чадаагүйн улмаас төрийн зүгээс зах зээлд хэт хутгалдан орох, төр өөрөө бизнесийн үүрэг гүйцэтгэж бизнест “өрсөлдөх”, төрийн өмчийн компани байгуулах дуршил нэмэгдэх, улсын төсөвт төрийн үрэлгэн зардал нэмэгдэх, төрөөс хэт олон зохицуулалт, дүрэм журам гаргаснаас хүнд суртал, авилгал, хээл хахууль нэмэгдэх, ОУБ-даас гаргадаг бүх төрлийн индексүүдээр Монгол улсын үнэлгээ тогтмол буурах ингэснээр Монголын эдийн засгийн өрсөлдөх чадвар буурах, хөгжлийн буруу сонголт хийхэд хүргэж байна. Иймээс төрийн зохицуулалтын тухай хууль санаачлан энэ хуулинд доорхи зарчмын заалтуудыг тусгах:

- Зах зээлийн зохицуулалт + бараг /квази/ зохицуулалт+төрийн /Засгийн газрын/ зохицуулалт гэсэн үндсэн 3 зохицуулалтыг тэргүүлэх ач холбогдол буюу тэргүүлчлэлээр нь эрэмбэлж хуульчилж өгөх. Тэгэхгүй бол тэргүүлчлэлээрээ хамгийн сүүлд байр учиртай төрийн зохицуулалтыг нэн тэргүүнд хэрэгжүүлэх бодлогын буруу практик сүүлийн жилүүдэд газар авлаа.
- Квази буюу бараг зохицуулалтыг өргөнөөр хэрэглэх нь эдийн засгийн төдийгүй нийгэм улс төрийн ач холбогдолтой болж байна. Гэтэл Монгол улсад энэ талаар ойлголт ч алга байна гэхэд хилсдэхгүй. Тийм учраас нэн тэргүүнд төрийн зарим чиг үүргийг /үнэн хэрэгтээ төр өөртөө сайн дураар наасан/ төрийн бус байгууллагууд, мэргэжлийн холбоодод яаралтай шилжүүлэх ажлыг 2013 оноос хэрэгжүүлэх. Үүний үр дүнд төрийн бус байгууллагууд, мэргэжлийн холбоод өөрсдийн зохицуулалтыг гаргаж тодорхой сектор, зах зээлийн асуудлыг шийдэх бүрэн боломжтой болно. Энэ нь “бараг” зохицуулалтын тодорхой жишээ болно.
- Төрийн зохицуулалт. Төр аливаа зах зээл, эдийн засгийн салбаруудын үйл ажиллагааг зохицуулахдаа хамгийн түрүүнд зах зээлийн зохицуулалтанд садаа болохгүй байх, “зах зээлийн бүтэлгүйдэл” /market failure/ гэж нэрлэдэг зүйл бодитойгоор болоод байгаа эсэхийг нягтлах, түүний дараа тухайн зах зээл, секторт бараг /квази/ зохицуулалт хэрэгжих боломжтой эсэхийг сайтар нягталан төрийн зохицуулалт хийх эсэх шийдвэр гаргах ба энэ нь төр, хувийн хэвшлийн түншлэлийн зарчмаар хэрэгжих гэдгийг хатуу мөрдлөг болгох ёстой.

ИЗННамаас дэвшүүлж буй төр ба зах зээлийн хоорондын зохистой харилцаа тогтоох тухай дээрх хандлага, бодлогыг хэрэгжүүлснээр Монгол улсад зах зээл чөлөөтэй хөгжих, эдийн засгийн хумигдсан эрх чөлөө тавигдах, төрийн зүгээс зах зээлд оролцох, зохицуулах үйл ажиллагаа оновчтой болох эхлэл тавигдах болно.

“Голланд өвчин”, “баялгийн хараал” гэж нэршсэн эдийн засгийн өсөлт, хөгжлийн буруу бодлогын шинж тэмдгүүд Монголын эдийн засагт сүүлийн 4 жилд хүчтэй

мэдрэгдэх болсон үед нэн түрүүнд яаралтай өөрчлөх бодлогын дээрх алхмуудаас гадна дараахь бодлогуудыг хэрэгжүүлэх шаардлагатай. Үүнд:

- уул уурхайн бус экспортыг дэмжих, хөгжүүлэх асуудлыг төрийн бодлогын тэргүүн ээлжинд тавих, үүний тулд тусдаа хөтөлбөрийг хувийн хэвшлийн манлайлалтайгаар хэрэгжүүлэх, төрийн зүгээс уул уурхайн экспортын орлогын тодорхой хэсгээс бүрэлдсэн “уул уурхайн бус экспортын хөгжлийн сан” байгуулах
- дээрх сан байгуулагдсан нөхцөлд ноос, ноолуур, мах, аялал жуулчлал гэх мэт уламжлалт экспортыг дэмжих нэгдсэн эх үүсвэртэй болохоос гадна уламжлалт бус, шинэ экспортын бүтээгдэхүүн төрөх боломж, сэжиг түлхэцийг бий болгох юм.
- уул уурхайн бус эдийн засгийн салбаруудын хүний нөөцийн хөгжилд онцгой анхаарахгүй бол ажиллах хүчний урсгал эдгээр салбараас уул уурхайн салбар илүү шилжих үйл явц хүчтэй болж уул уурхайн бус эдийн засгийн салбаруудад ихээхэн хүндрэл учруулж эхэллээ. Иймээс уул уурхайн бус эдийн засгийн салбаруудад шаардлагатай хүний нөөцийг бэлтгэх, тогтвор сууршилтай ажиллах эдийн засгийн хөшүүрэг бүхий тусдаа хөтөлбөр боловсруулах шаардлагатай. Тухайлбал, уул уурхайн бус эдийн засгийн салбаруудад хүн амын орлогын албан татваргүй болгох, нийгмийн даатгалын сан, түүний шимтгэл зэрэгт ажил олгогчдын тэгш оролцоо бүхий бүтцийг бий болгох
- инновац, нано болон биотехнологийн салбарыг хөгжүүлэхэд уул уурхайн том компаниудын санхүүгийн болон бусад дэмжлэгийг хөхүүлэн дэмжсэн хууль эрх зүйн болон менежментийн орчинг бий болгох, судалгаа ба хөгжилд зориулсан хөрөнгө оруулалтыг татвар ноогдох орлогоос чөлөөлөх
- гадаад худалдаа, түүний дотор хил худалдааг аймаг, бүс нутгийн хөгжлийн нэг гол хөшүүрэг гэж үзэн худалдаа, тээврийг хөнгөвчлөх, хилийн боомтуудыг хөгжүүлэх төрийн бодлогыг эрчимтэй хэрэгжүүлэх нь ажлын байр, уул уурхайн бус эдийн засаг, худалдааг дэмжих чухал алхам болно.

Орон нутаг, иргэдийн оролцоог хангахад дараахи алхамуудыг хийнэ.(2013-2015)

- Уул уурхайн салбарын нөөц ашигласны татварын олох орлогын 40 хүртэл хувийг орон нутгийн хөгжилд зарцуулагдах хууль эрх зүйн орчинг бүрдүүлэх
- Салбараас олж буй орлогын хэсгийг шууд хуваарилах замаар орон нутгийн төсвийн бие даасан бодлогыг хангах, улмаар төсвөө бүрдүүлэх, зарцуулах нөхцөл бололцоог олгоно.
- Орон нутгийн удирдлагын чадамжийг дээшлүүлэх, оролцоог бий болгох, хууль эрх зүй, удирдлагын туслалцаа үзүүлэх, боловсон хүчний асуудал, бүс нутгийн МСҮТ боловсон хүчний сургалт

- дадлагажилтыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэн шинээр ажлын байрыг бий болгох, ажлын байруудыг хангах
- Газар ашиглалтын орон нутгийн бодлогыг төрийн хэмжээнд нэгтгэж бэлчээрийн, газар тариалангийн, байгалийн нөөц ашиглалтын газруудыг нэгдсэн системээр зохицуулна.

Шигтгээ 1: “Инфляци”нэртэй мангасыг дарах ИЗНН-ын төлөвлөгөө

Иргэн та, сонин хэвлэлээр инфляци таны амьдралд сөргөөр нөлөөлж, түрийвчин дэх хэдэн бор төгрөгийг чинь хоосолж байдаг зүйлийн тухай бараг залхтлаа сонссон байх. Үе үе Засгийн газар, за тэгээд гол нь Монгол банкны хэдэн нөхдүүд бодлогын хүүг нэмж, энэ нь инфляцийг барихад хэрэгтэй гээд бараг 10 жил ой тойнд чинь цээжлэгдтэл ярьсан. Гэвч байдал огт өөрчлөгдөөгүй, юмны үнэ өсдгөөрөө л өсч таны амьдралд сөргөөр нөлөөлсөөр л...

Тэгвэл ИЗННам ямар бодлого санал болгож байна вэ?

- Юуны өмнө Монгол банкиг инфляцыг нэг оронтой тоонд оруул гэж олон жил шахсан бодлогоос УИХ татгалзаж, Монгол банкинд тийм даалгавар өгөхөө болих, бодлогын хүүг зөвхөн УИХ, Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хороо, түүний бүрэлдэхүүнд нь ордог Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлөөр олон нийтэд ил тодоор хэлэлцүүлдэг болох,
- өмнө дурдсан бүх төрлийн бизнесийг дэмжих арга хэмжээ аваад эхлэхээр эдийн засгийн идэвхижил нийт эдийн засагт мэдрэгдэнэ, үүний үндсэн дээр зах зээл идэвхижиж бараа, үйлчилгээний нийлүүлэлт сайжирч, саад бэрхшээл арилна. Товчлон хэлбэл, хүмүүсийн эдийн засгийн эрх чөлөө нэмэгдэнэ, энэ нь шударга өрсөлдөөнд эерэгээр нөлөөлнө, үнийн өсөлтийг сааруулна.

Шигтгээ 2: Махны нийлүүлэлт, хүртээмжийг сайжруулах

Монгол хүний хүнсний гол хэрэглээ болох махны нийлүүлэлтийг сайжруулах өнөөгийн төрийн бодлого нь явцуу, махны үнийн өсөлтийн шалтгаан нөхцлийг тодорхойлж чадаагүй, эрсдлийн дүн шинжилгээнд суурилаагүй, түр зуурын гал унтраах чиглэлд явж ирлээ.

- Иймд малын үүлдэр угсааг сайжруулах, ашиг шимийн гарцыг нэмэгдүүлэх замаар махны нөөцийг бүрдүүлэх, махны жижиглэнгийн үнийн хөөрөгдөлд нөлөөлж буй завсрын шат дамжлагыг цөөлөх зэрэг арга хэмжээг нэн даруй авч хэрэгжүүлэх,
- Зах зээлийн мэдрэмжтэй, хөрвөх чадвар сайтай, зохистой сүргийн бүтэц бүхий малчдын бүлгийг төрийн бодлогоор дэмжих, малжуулах зээлийг төр-арилжааны банкны хамтын ажиллагаанд түшиглэн хэрэгжүүлж, зээлийн дарамтнаас малчдыг чөлөөлөх боломжийг бүрдүүлэх,

- 2012 оны 4 сарын байдлаар л үзэхэд Монгол банкны "инфляцыг онилох" гэгч бодлогын хүүгээ нэмдэг бодлогын уршгаар арилжааны банкууд махны компаниудад зээл олгохгүй эсвэл маш хатуу нөхцөлтэйгээр зээл олгоно гэж байгаа нь мах бэлтгэлийн ажилд том садаа болж энэ нь эргээд 2013 онд махны үнийг өсгөх угтвар нөхцлийг бүрдүүлж байна. Иймээс энэ бодлогод яаралтай цэг тавих хэрэгтэй.

Шигтгээ 3: Бензин, шатахууны үнийг тогтворжуулах

2011 оны эцсээс эхэлсэн дотоод зах зээл дээрх шатахууны үнийн гэнэтийн огцом өсөлтийн шалтгааныг иж бүрэн судалж үзэхэд доорхи алхмуудыг авч хэрэгжүүлэх шаардлагатай нь харагдаж байгаа юм.

Үүнд:

- бензиний бөөний ба жижиглэнгийн худалдаанд 2 өөрөөр хандах: их төлөв уул уурхайн компаниудад бөөний үнээр нийлүүлж буй бензиний үнэд аливаа татаас, татварын хөнгөлөлт, дэмжлэг үзүүлэхгүй байх, харин жижиглэнгийн худалдааны үнэд нь зах зээл дээр үнийн савалгаа үүсгэхгүй байх хэмжээнд татварын болон бусад хөнгөлөлт, дэмжлэг үзүүлэх.
- бензиний үнийн хэлбэлзэлд валютын ханшны хэлбэлзэл маш их нөлөөтэй бөгөөд гэхдээ валютын ханшны эрсдлээс хамгаалах төрөл бүрийн хэлцлүүд төр ба компаниудын хооронд хийгддэггүй. Хийдэг болох нь бензиний үнийг тогтвортой барихад чухал нөлөөтэй ба түүнчлэн валютын нөөцийн маш бага хэсгийг бензиний 2 сарын нөөцийг бүрдүүлэхэд ашиглах хэрэгтэй.
- бензин нийлүүлэх гол улсын дотоод зах зээлийн үнээр бензиний тодорхой хэсгийг нийлүүлэх ажлыг Засгийн газар хоорондын шугамаар тохиролцох механизмыг бий болгох. Өөрөөр хэлбэл жижиглэнгийн үнээр зарах хэсэгтээ энэ механизмыг хэрэглэж болно.
- бензиний зах зээл дээр шударга өрсөлдөөн бий болгох, бүс нутгуудад бензиний нөөц бэлтгэх, агуулах сав гэх мэт дэд бүтцийг төр-хувийн хэвшлийн түншлэлийн механизм ашиглан бий болгох.
- газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээний хууль эрх зүйн үндсийг сайжруулж ил тод болгох, дотооддоо бензин үйлдвэрлэх төрөл бүрийн боломжуудыг хувийн хэвшилд нээж өгөх.

Дээрх дурдсан бодлогын алхмуудыг авч хэрэгжүүлэхээс гадна цалингийн хэмжээг улс төрийн зорилгоор нэмэх, шоудаж зарладаггүй байх, хавтгайрсан халамжийг хязгаарлаад, төсвийн үрлэгэн зардлыг багасгачихвал инфляци гэдэг үзэгдлийг гааруулахгүй байх бүрэн боломжтой.

3. Амьдрах орчин, байгаль хамгаалах шинэ хандлага

- Иргэд байгаль орчны асуудлаар мэдээлэл авах, шийдвэр гаргах явцад оролцох, эрүүл байгаль орчинд амьдрах хүний эрхийг шүүхээр хамгаалах цогц боломжийг бүрдүүлсэн **Аархусийн конвенцид** Монгол улс нэгдэн орно.
- Байгаль орчны тухай хууль тогтоомж шийдвэрийг багцлах биш харин ч асуудлыг **тус бүрчлэн иргэдийн санал, судалгаанд суурьлуулан шинэчлэн** боловсруулж, заалтуудын хэт ерөнхий, давхардуулсан зохицуулалтуудыг өөрчилнө. Байгаль орчны хуулийг амьдралд бодитоор хэрэгжүүлэхийн тулд холбогдох журам, стандартыг тодорхой, давхардсан утга санаагүй болгож шинэчилнэ. Байгууллагуудын бүрэн эрх, үүрэг, хэм хэмжээний давхардалаас үүсэн асуудлууд эзэнгүй орхигдож буй сөрөг зохицуулалтыг арилгана.
- Байгаль орчны **салбарын боловсон хүчний үнэлэмжийг өндөрсгөн**, Байгаль орчны хууль тогтоомжийг сахиулах, сурталчлах зэрэг ажлыг чанарын өндөр түвшинд гүйцэтгэх чадварлаг нөөц боловсон хүчнийг бэлтгэх, дадлагажуулах тусгайлсан хөтөлбөрийг албан болон албан бус боловсролын хүрээнд хэрэгжүүлнэ.
- 2030 он гэхэд Монгол улсын нутаг дэвсгэрийн 30 хувийг тусгай хамгаалалтанд авна гэсэн зорилтыг наашлуулж 2016 он болгох зорилт хэрэгжүүлнэ. **Улсын тусгай хамгаалалттай газарт газар нутгийн хэмжээгээр биш жинхэнэ судалгаанд суурилсан хамгаалалт, ашиглалтын шинэ менежмент** нэвтрүүлнэ.
- Хамгаалалтын ашиглалтын үйл ажиллагааг зохицуулсан үүргийг аль болох нутгийн өөрөө удирдах байгууллага, шинжилгээ судалгаа, аялал жуулчлалын төрийн бус байгууллагуудад шилжүүлнэ. Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын санаачилга, оролцоонд түшиглэсэн байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийн нөөцийг тогтвортой ашиглах, нөхөн сэргээх бодлогыг хэрэгжүүлнэ. Үүний тулд орон нутгийн өөрөө удирдах эрх үүргийг өргөжүүлэн, байгаль орчны удирдлагын төвлөрлийг сааруулна. Ингэснээр байгалийн нөөцийн тогтвортой даацтай менежментийг хөгжүүлэх, зөв зохистой эрхлэх талаар нутгийн өөрөө удирдах байгууллага бэхжих, бие даасан байдлын нөхцөл бүрдэнэ.
- Орон нутгийн иргэд, малчдын хууль эрх зүйн мэдлэг, мэдээллийг дээшлүүлэх, өөрсдийн хууль ёсны эрх ашгийг хамгаалах, эрхийнхээ төлөө тэмцдэг, НӨУБ-ын үйл ажиллагаанд оролцох, хяналт тавих чадварыг дээшлүүлэх зориолгоор иргэд, малчдын **чадавхийг дээшлүүлнэ**.
- Байгаль дэлхийгээ хүндлэн дээдэлж ирсэн өвөг дээдсийн уламжлалт ёс заншилд тулгуурлан залуу үеийнхэнд байгаль орчноо хайрлан хамгаалах, зохистой хэрэглээнд төлөвших, байгаль орчноо тэтгэн сайжруулах арга ухаанд суралцах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицож, амьдрах ур чадварыг эзэмшүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

- Эрдэс баялгийн салбарт хяналт-мониторингийн иргэний нийгмийн болон хөндлөнгийн хараат бус, мэргэжлийн тогтолцоог хөгжүүлнэ

ЭРҮҮЛ ХҮНС – ЭРҮҮЛ АМЬДРАЛ

Монгол хүн Таныг амьд явах үндсэн эрхээ эдлэхэд / Монгол Улсын Үндсэн Хуулийн 16 дугаар зүйлийн 1 дүгээрт заалт/ шаардлагатай эрүүл, аюулгүй, амин дэмээр баялаг, тэжээллэг хүнсийг боломжийн үнээр худалдан авах батлагаагаар хангах бодлого хэрэгжүүлнэ.

ИЗНН-ын Хүнсний бодлого нь дараахи 3 тулгуур хэсэгтэй байна:

1. Эрүүл, аюулгүй хүнс
2. Тогтвортой хангамж
3. Ухаалаг, жигд хүртээмж

Энэхүү цогц бодлогын үр дүнд иргэн Таны ширээн дээр өдөр бүр аюулгүй, тэжээллэг. “Монгол” хүнс тавигдах болно.

Баримт 1 . Монгол хүний хүнсний ногооны хэрэглээ зөвлөмж хэмжээнээс 35.5% доогуур, өөх тосны хэрэглээ 1.5 дахин их, хоол тэжээлээс авч буй С амин дэмийн хэмжээ дөнгөж 24.5 %, кальци 48.8 % тай байна. /Халдварт бус өвчинд нөлөөлөх хоол хүнсний эрсдэлт хүчин зүйлс” судалгааны үр дүнгээс, 2010/

1. ЭРҮҮЛ, АЮУЛГҮЙ ХҮНС – “Эрүүл хүнс нь ухаан саруул, бие эрүүл, эрч хүчтэй Монгол хүн оршихуйн үндэс бөгөөд эмийг хоол мэт бус хүнсийг тан лугаа хэрэглэж сурцгаая”

- Гурван цагаан хорын агууламж өндөртэй, химийн будаг, хиймэл амт, үнэр оруулагч, тогтворжуулагч, нөөшлөгч бодис их хэмжээгээр агуулсан хүнсний бүтээгдэхүүний импорт, хангамжийг татварын бодлогоор хязгаарлах (төрөл бүрийн чихэр, шоколад, давсалж, нөөшилсөн бүтээгдэхүүн) ;
- Хатуулаг өндөртэй согтууруулах ундааны дотоодын зах зээлийн борлуулалтад ноогдох татварыг эрс өсгөх, харин экспортыг бүх талаар дэмжих;
- Органик, зохицуулах үйлчилгээтэй хүнсний импорт, үйлдвэрлэлийг татвараас чөлөөлөх, Органик Хөдөлгөөнүүдийн Олон Улсын Холбооноос гаргасан стандартуудыг манай нөхцөлд зохицуулж нутагшуулах, Органик болон зохицуулах үйлчилгээтэй хүнсний бүтээгдэхүүнийг батлагаажуулах хөндлөнгийн этгээдийн ажиллах хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх;
- Сургуулийн “Үдийн цай” хөтөлбөр, улсын үйлдвэрийн газрууд, уул уурхайн компаниудын хүнсний хэрэгцээнд Монгол хөрсөнд тарьж ургуулсан хүнсний ногоо, үр тариа, Монголын талд өсгөж, тэжээсэн малын мах, сүү түүгээр үйлдвэрлэсэн Эх орны хүнсний бүтээгдэхүүнийг тэргүүн ээлжинд нийлүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлэх;

- Цэцэрлэг, сургууль, олон нийтийн үйлчилгээний газар ундны усны үнэгүй цэг ажиллуулах, хүүхэд багачуудын амны цангааг хийжүүлсэн ундаагаар биш харин цэвэр усаар тайлж занших;
 - Хүнсний шошго, сурталчилгаагаар дамжуулан иргэдийг төөрөгдүүлж, хуурч мэхлэх ажиллагаатай шийдэмгий тэмцэх, Хүнс, хөдөө аж ахуйн томоохон арга хэмжээний үеэр зөвхөн шилдгийг шалгаруулах биш Төрийн нэрийн өмнөөс “Нэр хугарахаар яс хугар” гэсэн уриан дор шаардлага хангаагүй бүтээгдэхүүн үйлдвэрлэгч болон импортлогчийн талаарх сэрэмжлүүлгийг олон нийтэд хүргэх;
 - “Ниргэсэн хойно хашгирав” гэдэгтэй адил хүнсийг үйлдвэрлээд зах зээлд гаргасан хойно нь хянадаг тогтолцооноос татгалзан, тариан талбай малын бэлчээрээс хэрэглэгчийн ширээ хүртэлх хүнс үйлдвэрлэлийн бүтэн мөчлөгийн эрсдэлтэй цэгүүдэд үр дүнтэй хяналт тавих тогтолцоонд шилжих, Үүний тулд олон улсын хэмжээнд туршаад үр дүнг нь судлачихсан “Сайн үйлдвэрлэлийн дадал”, “Аюулын дүн шинжилгээ, эрсдэлтэй цэгийн хяналт”-ын тогтолцоо, мөн системийн хувьд сайжруулсан эрсдлийн дүн шинжилгээний олон улсын стандарт ISO 22000-г хүнсний үйлдвэрүүдэд нэвтрүүлэхэд бодлого, арга зүйн дэмжлэг үзүүлэх;
 - Эхний ээлжинд мах боловсруулах, хиам, махан бүтээгдхүүн, өндөг болон бялууны зэрэг эрсдэл өндөртэй үйлдвэрүүдэд дээрх тогтолцоог нэвтрүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлэх;
 - Эрсдэлд суурилсан, оновчтой, хөрөнгө хүчээ зөв хуваарилсан хүнсний аюулгүй байдлын бодлого боловсруулж, хэрэгжүүлэх, төр захиргааны бүтэц бий болгох (Дэлхийн Хүнсний Батлагаат Байдлын Зөвлөлөөс гаргасан удирдамжийн дагуу Монгол улсын Хүнсний Батлагаат байдлын Тогтолцооны Загварыг боловсруулах, ХХААХҮЯ, ЭМЯ, БОЯ, Мэргэжлийн хяналт, ШБӨХЗГ, гадаадын төсөл хөтөлбөр, орон нутгийн засаг захиргааны байгууллага-ын үйл ажиллагаанд нэгдсэн дүгнэлт хийж, хөрөнгө оруулалт, тэргүүлэх чиглэлийн давхардлыг арилгах, эрх үүргийн хуваарилалтыг оновчтой болгох, иргэний нийгмийн байгууллагын оролцоог нэмэгдүүлэх);
 - Газар зүйн заалтад тулгуурлан хүнсний гарал үүслийг тодорхойлох эх үүсвэрийг тавих, шаардлага хангаагүй хүнсийг зах зээлээс эргүүлэн татах оновчтой арга механизмыг нэвтрүүлэх;
 - Бүтээгдэхүүний стандартуудыг Хүнсний хууль эрх зүйн Хороо-Кодексийн зөвлөмжийн дагуу сайжруулахаас гадна үйлдвэрлэлийн үйл ажиллагааг баримжаалсан хүнсний стандартуудыг боловсруулах, мөрдүүлэх;
2. **ТОГТВОРТОЙ ХАНГАМЖ - “Монгол улсын хүнсний тусгаар тогтнол Үндэсний аюулгүй байдлын нэг чухал бүрэлдэхүүн хэсэг мөн”**

Баримт 2. Монгол улс жилд дунджаар 2247 сая ам.долларын хүнсийг импортлож байгаа нь 1990 оны үетэй харьцуулахад даруй 3.6 дахин нэмэгдсэн бөгөөд нийт хүнсний нийлүүлтийн 56 %-ийг импортын хүнсний бүтээгдэхүүн эзлэж байна. Мөн орлогын тэгш байдлын Жини коэффициент 37% тай байгаа нь хүнсний хүртээмж тэгш бус байх үндсэн шалтгаан болж байна /НҮБ-ын ХХААБ, Хүнсний аюулгүй байдлын статистик үзүүлэлт, Монголын улс, 2011 он Холбоос: http://www.fao.org/fileadmin/templates/ess/documents/food_security_statistics/country_profiles/enq/Mongolia_E.pdf/

- Өртөг шингээгүй түүхий маханд экспортын албан татвар ногдуулах, квот тогтоох;
- Хүн амын төвлөрөл ихтэй томоохон төв суурин газарт стратегийн хүнсний агуулах, зоорийг байгуулах ;
- Дотоодын үйлдвэрлэлээр хангах бололцоо бүхий зарим нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүнийг импортлох тоо хэмжээнд квот тогтоох, тарифын болон тарифын бус зохицуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх;
- Монгол улсын хүнсний тусгаар тогтнолыг хамгаалахад иргэн бүрийн оролцоог хангах зорилгоор нөхөрлөлийн зарчимд суурилсан өрхийн аж ахуйн хөрөнгө оруулалтын хэлбэрийг нэвтрүүлэх;
- Уламжлалт арга барилд суурилсан, тогтвортой хөгжил болон байгаль орчинд ээлтэй чиглэлийг баримжаалсан өрхийн үйлдвэрлэл, хөдөө аж ахуй-хүнс үйлдвэрлэлийн цогцыг татвар, татаасын бодлогоор дэмжин, хөгжүүлэх;

Баримт3. Хүн амын 26% нь хоол тэжээлийн дутагдалтай, бага насны 6 хүүхэд тутмын 1 нь өсөлт хоцролттой байна. /НҮБ-ын ХХААБ, Дэлхийн Өлсгөлөнгийн Индексийн тайлан, -2011 он, “Хүүхэд хөгжил-2010” судалгааны дүнгээс/

3. ЖИГД, УХААЛАГ ХҮРТЭЭМЖ - “Нийгмийн эмзэг хэсэгт чиглэсэн хүнсний хангамжийн ялгавартай бодлого”

- Орон гэргүй иргэд, нэн ядуу өрхөд хүйтний улиралд халуун шөлний үйлчилгээ үзүүлэх хөдөлгөөнт цэгүүдийг ажиллуулах;
- Хөдөө орон нутгийн хүнсний тэнцлийг бодитой тооцон, алслагдсан аймаг орон нутагт үйл ажиллагаа явуулж буй хүнсний үйлдвэрлэл, худалдаа эрхлэгчдийг татварын бодлогоор дэмжих;

ДААТГАГДСАН ЭРҮҮЛ АМЬДРАЛ

Нийгмийн эрүүл мэндийг сайжруулах чиглэлд эрс өөрчлөлт хийнэ.

- Аймаг, дүүргүүдэд олон улсын жишигт нийцсэн лаборатори бүхий Нийгмийн Эрүүл мэндийн төвүүдийг байгуулж, хүн амын эрүүл мэндийг хамгаалах, дэмжих, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх чиг үүрэг бүхий үндэсний цогц бүтцийг бий болгоно. Сум бүрт биеийн тамир, спортынзаал, ил талбай барьж, эрүүл ахуйн мэргэжилтэн ажиллуулна.
- Нийслэлд хүүхдийн эмнэлэг, дүүрэг бүрт нэгдсэн эмнэлэг шинээр барина.
- Эх барихын болон НҮЭМ-ийн нэн шаардлагатай эм хэрэгслийн санхүүжилтийг төсвөөс бүрэн хариуцдаг болно.
- Эмнэлгийн тусламж үйлчилгээнээс алслагдсан хүн амд зориулсан "Эхийн амаржих байр"-ны зардлын санхүүжилтийг төсвөөс бүрэн хариуцдаг болно.
- Эмнэлэг, тусламж үйлчилгээний олон улсын стандартыг Монголын эрүүл мэндийн салбарт нутагшуулах үе шаттай арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.
- Анагаах ухааны их, дээд сургуульд сувилагч мэргэжлээр элсэгчдийн тоог нэмэгдүүлэх, шаталсан сургалтын хэлбэрээр сувилагчдыг бэлтгэх тогтолцоог дэмжиж, эмч, сувилагчийн зохистой харьцааг 1:2 бүрдүүлнэ.
- Өндөр хөгжилтэй оронд урт, богино хугацааны сургалтанд хамрагдах эмнэлгийн мэргэжилтний тоог тасралтгүй нэмэгдүүлэх, гаднаас өндөр ур чадвартай мэргэжилтнийг урьж эх орондоо ажиллуулах бодлогыг тууштай дэмжинэ.

Эрүүл мэндийн даатгалын цоо шинэ тогтолцоо руу шилжинэ.

- Иргэн бүрийг хөрвөх чадвартай, эрүүл мэндийн даатгалын ваучертай болгоно.
 - Гэр бүлийн гишүүдээс хэн нэг нь өвдөхөд ваучераа нийлүүлж, эмчилгээний зардалд нэмэрлэх боломжийг бүрдүүлнэ.
 - Эмнэлгүүд ваучер цуглуулах өрсөлдөөнд орсноор тусламж үйлчилгээний хүртээмж, чанар сайжирч, улмаар эрүүл мэндийн даатгалын хүнд суртал, чирэгдэл арилна.
 - Ваучерийг нэвтрүүлснээр эрүүл мэндийн салбарын санхүүжилт нэмэгдэж, ажиллагсдын нийгмийн хангамж сайжирна.
- Төрөөс даатгалын төлбөрийг нь хариуцахаар хуульчлагдсан /хүүхэд, тэтгэврийнхэн, тахир дутуу хүмүүс, хугацаат цэргийн албан хаагч, хүүхдээ 2 нас хүртэл асарч буй эхчүүд гэх мэт/ даатгуулагчдын эрүүл мэндийн даатгалыг нэмэгдүүлнэ.
- Ажилгүйчүүдийг эрүүл мэндийн даатгалд хамруулж, ажилгүйдлийн тэтгэмжээс шимтгэл авдаг журамд шилжинэ.
- Малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, албан бус секторт ажиллагсдыг эрүүл мэндийн даатгалд хамруулна.
- Төрөлтийг эрүүл мэндийн даатгалд хамруулна.

Нийгмийн даатгалыг бүхэлд нь хариуцлагажуулж, хүний төлөө үйлчилдэг тогтолцоо болгон өөрчилнө.

- Тэтгэврийн даатгалын нэрийн дансны мэдээллийг даатгуулагчдад хүргүүлэх, даатгуулагч нь нэрийн дансан дахь хуримтлалаа бүрэн захиран зарцуулах, гэрээслэлийн дагуу өв залгамжлагчдаа шилжүүлэх, орлогод тооцсон хүүг ил тод мэдээлэх зэргийг зохицуулсан эрх зүйн шударга орчинг бүрдүүлнэ.
- Гадаад оронд хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа Монгол иргэдийг нийгмийн даатгалд хамруулах хууль эрх зүйн зохицуулалтыг хийнэ.
- Нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг барьцаанд тавих, нийгмийн даатгалын сангийн хөрөнгөөр шинээр хуулийн этгээд үүсгэн байгуулах зэрэг үйл ажиллагаа эрхлэхийг хуулиар хатуу хориглоно.

САЙН БОЛОВСРОЛ-САЙХАН АМЬДРАЛЫН ҮНДЭС

Боловсролыг дээдлэдэг төсөв санхүү, бүтэц зохион байгуулалтын тогтолцоонд шилжих эрх зүйн өөрчлөлтийг хийнэ.

- “Монгол хүн” судлалыг дэмжин хөхүүлснээр Үндэсний боловсролын тогтолцоог өөрчлөх үндсийг бүрдүүлнэ.
- Монголын ирээдүй болсон хүүхэд, залуучуудын оюун ухаанд бугласан амьдралын чанарыг материаллаг талаас нь тахиж шүтэх ёс суртахууны хандлагыг өөрчлөх боловсролын цогц хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэх
- Бүх шатны сургуулийн багш нарын сургалт зохион байгуулах арга барилд тогтолцооны өөрчлөлт хийж, сурагчдын сурч, танин мэдэх үйл ажиллагааг төлөвлөн хөтөлж, идэвхижүүлэн зохион байгуулах үндсэн чиг үүрэг бүхий багш сурган хүмүүжүүлэгчдийг төлөвшүүлнэ.
- Багш нарыг давтан сургалтад тасралтгүй хамруулж, чадавхийг нь нэмэгдүүлэх бодлого баримтлана.
- Багш нарыг орон сууцжуулах, хөдөө орон нутагт багшлах боловсон хүчнийг дэмжих, сургалтад хамруулах үйл ажиллагааг санхүүжүүлэх зорилгоор “Багш” сан байгуулж, ажиллана.
- Хувийн секторээс боловсролд хөрөнгө оруулахыг дэмжсэн эрх зүйн орчинг бүрдүүлнэ.
- Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт болон оюутны үүсгэл санаачлага дээр үндэслэсэн бизнесийн төлөөллийн байгууллагын дэргэд “Оюутны ажил эрхлэлтийг дэмжих сан”-г байгуулж, төрийн дэмжлэг үзүүлнэ.
- Их дээд болон мэргэжлийн боловсролын сургуулийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд хариу өгөх чадамжийг дээшлүүлж, улс орны хөгжилд нэн тэргүүнд шаардлагатай боловсон хүчин бэлтгэх үндэс суурийг тавина.
- Их, дээд сургууль, коллежид суралцагчдын бүтцэд ядуу өрхийн хүүхдийн хувь хэмжээг нэмэгдүүлэх замаар нийгмийн орлогын тэгш бус байдлыг багасгах арга хэмжээг цогц байдлаар хэрэгжүүлнэ.
- Улс орны нийгэм, эдийн засгийн хөгжлийн бодлогыг боловсруулахдаа тухайн салбарт хийгдсэн шинжлэх ухааны үндэслэлтэй эрсдлийн үнэлгээнд

тулгуурлах боломжийг бүрдүүлж, салбарын эрдэмтдийн судалгаа, шинжилгээний үр дүн төрийн бодлогод нөлөөлөх сувгийг нээнэ.

- Оюуны хөдөлмөрийн үнэлэмжийг дэлхийн түвшинд ойртуулж, эрдэмтэд, шинжлэх ухаан, технологийн боловсон хүчний хөдөлмөрлөх нөхцөл, амьжиргааны баталгааг сайжруулна.

СОЁЛ УРЛАГИЙН ХӨГЖИЛ-САЙХАН АМЬДРАЛЫН ИЛРЭЛ

ИЗНН нь ард түмнийхээ хөгжил дэвшлийн төлөөх хүсэл эрмэлзлийг дэмжин хөглөх, уриалан манлайлах зорилгоор соёл урлагийн хөтөлбөрийг товч томъёолон хүргэж байна.

Монгол үндэстний соёлын биет болон биет бус өвийг хойч үедээ өвлүүлэх, хадгалан хамгаалах зорилгоор соёл урлагийн салбарын хөгжлийг дэмжих төрийн бодлогын таатай орчинг бүрдүүлэх

Монгол оюуны үнэ цэнэтэй бүтээл, үндэсний бахархл туурвигдах нөхцөл бүрдэнэ.

МОНГОЛЫН БАЯЛГИЙГ МОНГОЛ ХҮҮХДЭД

Монгол хүүхэд- Монголын үндэсний баялаг

Бодит байдал: 2010 оны байдлаар улсын хэмжээнд 200 мянга шахам цэцэрлэгийн насны хүүхэд байгаа бөгөөд 167 мянган хүүхэд 864 цэцэрлэгт хүмүүжиж байна. Мөн онд 45 мянган хүүхэд сургуульд, 61 мянган хүүхэд цэцэрлэгт элсэн орсон байна. Одоо 760 ЕБС-д 514 мянган хүүхэд суралцаж байна. Нийслэлийн сургууль, цэцэрлэгүүдэд анги дүүргэлт нормоос хэтэрч нэг ангид 40-50 хүүхэд сурч, 3 ээлжээр хичээллэж байгаа сургуулиуд олон байна.

- Хүүхдийн хүмүүжил боловсролд олон нийтийн оролцоо, нийгмийн хариуцлагыг өндөржүүлэх зорилгоор сургууль, цэцэрлэгээс гадна төр засгийн болон хувийн хэвшлийн байгууллагууд, үзвэр, үйлчилгээний газрууд, хувь хүн бүр хүүхдийн сайн сайхны төлөө үүрэг хариуцлага хүлээдэг механизмыг бий болгоно.
- Хүн ам төвлөрсөн газруудад хүүхдийн цэцэрлэг, сургуулийн хүрэлцээг эрс нэмэгдүүлэх зорилгоор хүүхдийн ясли, цэцэрлэг, сургуулийг олноор барина.
- Нийслэлд шинээр 2 төрөх эмнэлэг барина.
- Анагаах ухааны сургуулиудад хүүхдийн эмч, сувилагч бэлтгэдэг болгоно.
- Дунд сургуулиудад хүүхдийн эмч ажиллуулна.
- Хүүхдийн сүүний газар, сувиллын эмнэлэгүүдийг хот, хөдөөд байгуулна.
- Хүүхэд залуучуудын хөгжих орчин нөхцлийг бүрдүүлэх зорилгоор спортын ордон, клубууд, урлаг соёлын газрууд, судалгаа шинжилгээний танин мэдэхүйн үйл ажиллагаа явуулах ордон, лаборатори байгуулах ажлыг төрөөс болон компаниудын нийгмийн хариуцлагын хүрээнд зохион байгуулна.

- Гэр бүл, хүүхэд, залуучуудын асуудал хариуцсан бодлогын яам байгуулна.
Бодит шаардлага: 2000-аад оны дунд үеэс манай улсын төрөлтийн түвшин харьцангуй тогтворжиж 2008 оны байдлаар 28.1% нь 0-14 насны хүүхэд, 65.8% нь 15-59 насныхан эзэлж, насны бүтцийн хувьд ихээхэн өөрчлөгдөн "Хүн амын цонх нээгдэх" таатай үе эхэлсэн байна. 2011 оны байдлаар дээрх хэмжээ өсч 67% болжээ. Хэтийн тооцооноос харахад хөдөлмөрийн насныхны нийт эзлэх хувь 2025 оныг хүртэл 66.4%-аас буурахгүй байгаа нь "Хүн ам зүйн цонх" үе манай оронд 2025-2030 он хүртэл үргэлжлэхээр байгааг харуулж байна.
- Хүүхдийн хүмүүжил боловсролын асуудлыг ерөнхийд нь бус систем дэс дараатайгаар тухайлбал "Өлгийтэй нялхаас бага балчир нас хүртэл", "Сургуулийн өмнөх насны хүүхэд", "сургуулийн наснаас өсвөр насанд хүрэх хүртэл", "Сургуулийн өмнөх боловсрол Улаанбаатарт" гэх мэт үе шаттайгаар ажил, арга хэмжээ авч үр дүнг тооцон ажиллах арга хэлбэрийг нэвтрүүлнэ.
- Залуу эцэг эхийн, хүүхдийн боловсрол хүмүүжлийн талаарх сурган хүмүүжүүлэх мэдлэг чадварыг дээшлүүлэх ажлыг зохион байгуулж буй хувийн хэвшил, ИНБ-ын үйл ажиллагааг дэмжинэ.
- Хүүхдийн цэцэрлэг, сургуулийн хүрэлцээг эрс нэмэгдүүлэх, шинээр баригдаж буй орон сууцны хорооллуудад хүүхдийн цэцэрлэг, сургуулийг барих, тэдэнд ээлтэй орчин бүрдүүлэх бодлогыг дэмжинэ.
- Хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах, төрөх газруудыг брх, нялхсын эрүүл мэндийн үзлэг үйлчилгээг чанартай болгох, хүүхдийн эмч нарыг бэлдэх цогц бодлого явуулна.

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ Ч ХӨГЖЛИЙН ТЭМҮҮЛЭЛТЭЙ ИРГЭД

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөгжлийг дэмжсэн оновчтой, цогц шинэ тогтолцоог нэвтрүүлнэ. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний сурч, боловсрох эрхийг хангахын төлөө ажиллана.

Бодит байдал: 2010 оны Хүн ам орон сууцны тооллогоор хөгжлийн бэрхшээлтэй 108.1 мянган хүн байгаа нь суурин хүн амын 4.1 хувийг эзэлж байна. Үүнээс харвал 0-14 насны 9461, 15-19 насны 6390 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд залуучууд байна. Гэхдээ Монголын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагуудын үндэсний холбооны 2008 онд хийсэн судалгаагаар 32516 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд байна гэжээ. Одоогоор Улаанбаатар хотод тусгай сургалтай 6 сургуулийн 4 нь оюуны бэрхшээлтэй, 2 нь сонсголын болон харааны харааны бэрхшээлтэй хүүхдүүдэд тусгай хөтөлбөрийн дагуу сургалт явуулдаг. 1990 оноос хойш хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ердийн сургуульд тэгш хамруулах бодлого нэвтрүүлсэн хэдий ч хэрэгжүүлэх тогтолцоо, төсөв, боловсон

хүчин байхгүйгээс дунд, ахлах ангиудад хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн дөнгөж 15 % нь хамрагдаж бусад нь сургууль завсарддаг байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй айлын хүн бүр хөдөлмөрлөх боломжгүйгээс /хүүхдээ харах/ тэд төрөөс үзүүлж байгаа үйлчилгээний ба орлогын хомсдолд орж байна.

Баримт. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн 50 гаруй хувь нь бага насандаа сургуульд суралцдаг боловч анги дэвших тутам энэ үзүүлэлт 14 хувь болтлоо буурдаг бөгөөд 60 гаруй хувь нь орлогын эх үүсвэргүй, нэн ядуу өрхөд амьдардаг.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөөлөлтэй уулзаж, тэдний зовлон бэршээл, тулгамдсан асуудлыг шийдэх талаар санал бодлыг нь сонсох явцад ХБИ-д зориулсан эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын цоо шинэ тогтолцоог нэвтрүүлэх шаардлага байгааг бид ойлгосон юм.

- ХБИ-ийн асуудал хариуцсан төрийн байгууллага/нэгжийг байгуулна. ХБИ-ийн хөгжлийн асуудлыг цогцоор нь шийдвэрлэхэд нийгмийн хамгаалал, халамж, эрүүл мэнд, боловсрол, зам тээвэр барилга, дэд бүтэц зэрэг олон салбарын хамтын ажиллагаа нэн чухал бөгөөд ХБИ-ийн эрхийг хамгаалдаг, хөгжил, хөдөлмөр эрхлэлтийг нь дэмждэг мэдээлэл зөвлөлгөө өгдөг төрийн байгууллага зайлшгүй үгүйлэгдэж байна.
- Төрөлхийн Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг 25 нас хүртэл нь нийгмийн халамж, боловсрол, эрүүл мэндийн суурь үйлчилгээнд цогцоор нь жигд, тогтмол хамруулах зорилгоор "ХАЛАМЖ 0-25" гэсэн хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлнэ.
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэний асуудлыг нийгэмд хүргэх, хууль, хөтөлбөрийн хэрэгжилтийг сайжруулах, хамтын ажиллагааг дэмжих зорилгоор Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн чуулга уулзалтыг 2 жил тутам зохион байгуулна.
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд тусалж дэмждэг ТББ, эцэг эхчүүдийн холбоодод төсвөөс дэмжлэг үзүүлж, төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжилтийг хангаж ажиллана.
- Хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг (ХБХ) бүртгэх үйл ажиллагааг орон нутгийн эрүүл мэндийн байгууллагын шугамаар гүйцэтгэж, тогтмол шинэчлэгдэх мэдээллийн сан байгуулна.
- 0-5 настай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан эрт дэмжлэгийн хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлнэ.
- Тусгай сургуулиудын тоог нэмэгдүүлж, бүсийн төвүүдэд тусгай сургууль шинээр байгуулна.

- ИЗНН хөгжлийн бэрхшээлтэй ч хөгжлийн тэмүүлэлтэй иргэдэд зориулж "Тэмүүлэл" зээлийн сан байгуулж, мэдлэг ажил эрхлэлтийг дэмжсэн бодлого хэрэгжүүлнэ.
- Сэтгэл зүй, нөхөн сэргээлт, хэл засал болон хөгжлийн сургалтын төвүүдийг Улаанбаатар хотын дүүрэг болон аймаг бүрт байгуулна. Энэ чиглэлийн хувийн хөрөнгө оруулалтыг хөхүүлэн дэмжинэ.
- Нийтийн унаа, нүхэн гарц, зам зэргийг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан стандартыг хангахуйц, тэдэнд таатай байхаар өөрчилнө.
- Тусгай хэрэгцээний боловсролын багш нар, сэргээн засал болон хэл заслын мэргэжилтнүүд, сэтгэл зүйч зэрэг хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд иргэдтэй ажиллах боловсон хүчнийг дотоод болон гадаадын сургуулиудад бэлтгэх хөтөлбөрийг төсвөөс санхүүжүүлэн хэрэгжүүлнэ.

ӨРХ ТЭРГҮҮЛСЭН ЭМЭГТЭЙЧҮҮД

Жишээ 1:

Цамбагаравын арын есөн давхар 14 дүгээр байрны нэгдүгээр орцонд жижүүрийн ажилтай Ш.Жавзанханд 38 настай. Гурван хүүхдийн эх, өрх толгойлсон эмэгтэй. Том хүү нь эгчийнд нь байдаг бөгөөд хоёр охиныхоо хамт шатны хонгилын доорх өрөөнд амьдардаг. Нэгэн цагт тэрбээр жирийн малчин, айлын жаргалтай гэрийн эзэгтэй байжээ. Малаа зуданд алдаж, нөхөр нь өөр хүнтэй сууж хаяж явснаас, гурван хүүхдээ хөтлөөд Завханаас 7 жилийн өмнө хотод иржээ. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 140 гаруй мянган төгрөгийн цалингаараа амьдралаа залгуулаад байдаг аж. Том хүү нь зундаа барилгын ажил хийж ээждээ нэмэр болдог.

(Өнөөдөр сониноос...)

Жишээ 2:

Гачуурт тосгоны иргэн Д.Бадамцэцэг

Өрх толгойлсон, дөрвөн хүүхэдтэй, өөрийн гэсэн орон гэргүй эмэгтэй. 2001 онд Дархан-Уул аймгаас нүүж ирсэн. Айлын гурван ханатай гэрт, айлын хашаанд амьдарч байна. Том хүүхдүүд нь ажилгүй. Нөхөр нь хаяж явснаас хойш айлын хашаанд толгой хорогдож, арай ядан амь зууж байна. Тохирох ажил олддоггүйгээс тосгоны захиргаа, сургууль, цэцэрлэгийн багш, ажилчдад бууз, цай зарж хоногийнхоо хоолны мөнгийг аргацаадаг.

(www.mongolnews.mn сайтаас...)

Тоо баримт 1:

Статистикийн газраас гаргасан судалгаагаар орон даяар 81.2 мянган эмэгтэй өрх тойлгойлон амьдарч, тэдний гар дээр 300 мянга гаруй хүүхэд өсч, хүмүүжиж байна. Тэдний дийлэнх нь 3-4 хүүхэдтэй. Амьдралын хэцүү бэрхийг даван туулах боломж, чадвар байхгүйгээс 60 гаруй хувь нь ядуу, 20 орчим хувь нь нэн ядуу амьдарч байна. Өөрөөр хэлбэл, боломжийн амьдралтай өрх толгойлсон эмэгтэй маш бага хувийг эзэлж байгаа юм. Тэд айлын хаяа бараадаж, орцны жижүүр хийж, хүндхэн нөхцөлд хоног өдрийг аргацааж байна.

Тоо баримт 2:

- Гэр бүлийн хүн нь хаяж явсан, нөхөр нь архинд донтсон, болон бусад шалтгаанаас болж өрх толгойлсон эмэгтэйчүүдийн тоо жилд 3-4 мянгаар нэмэгддэг.
- Өрх толгойлсон эмэгтэйчүүдийн 60 хувь нь ажилгүй.
- 1990 оноос хойш салсан гэр бүлийн 70 гаруй хувь нь 0-15 насны хүүхэдтэй байжээ.
- Нэн ядуу өрхийн 24.6 хувь, ядуу өрхийн 18.3 хувийг өрхийн тэргүүлэгч нь эмэгтэйчүүд бүхий өрх эзэлж байна.
- Гэрлэлт өмнөх оныхоос 3,3 хувиар нэмэгдсэн хэдий ч гэр бүл цуцлалт 26,2 хувиар өсчээ.

Бас нэг жишээ: Махимпэкс ХК-ны ажилчдын 80 хувь нь эмэгтэйчүүд, тэдний 60 хувь нь өрх толгойлсон эхчүүд байна.

Өнөөдрийн нөхцөл байдал

- Дөрөв ба түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон, 45 насанд хүрсэн эхчүүдэд сард 53.800 төгрөгийн халамжийн тэтгэвэр олгодог.
- Гурав ба түүнээс дээш тооны 14 хүртэлх насны хүүхэдтэй өрх толгойлсон эхчүүдэд жилд нэг удаа 60.000 төгрөг олгодог.
- Өрх толгойлсон эмэгтэйчүүдэд тусгайлан зориулсан ямар нэгэн төсөл, хөтөлбөр байхгүй.

Тэдэнд тулгамдаж байгаа гол асуудлууд юу вэ?

- Орон байрны асуудал
- Өрхийн орлого
- Хүүхдүүдийнх нь боловсрол хүмүүжлийн асуудал
- Ясли, цэцэрлэгийн хангамж
- Хөдөлмөр эрхлэлтийн асуудал
- Гэр бүлийн хүрээний архидалт
- Эрүүл мэндийн үйлчилгээний хангамж

Асуудлыг шийдэх ИЗНН-ын арга зам:

- Эмэгтэйчүүд, эхчүүд толгойлж буй өрхийн онцлог байдалд тохирсон ядуурлыг бууруулах ялгавартай бодлого, арга хэмжээг авч хэрэгжүүлэх
- Асуудлыг зөвхөн төрийн хүчээр шийдвэрлэх гэж оролдох биш, өмчийн бүхий л хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллага, иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, тэдгээрийн үйл ажиллагааны уялдаа холбоог хангах байдлаар асуудалд хандах
- Санхүүгийн эх үүсвэр, бодит нөөцийг үр ашигтайгаар зарцуулах
- Асуудлыг аль болох өөрсдийнх нөөц бололцоог дэмжих замаар өөрсдийнх нь оролцоотойгоор шийдвэрлэх

ИЗНН-ын Хөтөлбөрийн зорилтууд:

- Өрх толгойлсон эмэгтэйчүүдэд зориулсан орон байрны нөхцлийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- Сургууль завсардсан хүүхдэд боловсрол нөхөн олгох хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.

- Эдгээр өрхийн 0-5 хүртэл насны хүүхдийн хоол тэжээлийн хангамж, бүтцийг сайжруулахад дэмжлэг үзүүлнэ. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, хот, суурин газрын орчны бохирдлыг бууруулах үйл ажиллагаанд өрх толгойлсон эмэгтэйчүүдийг татан оролцуулах замаар орлогын эх үүсвэрийг нь нэмэгдүүлнэ.
- Сул чөлөөтэй ажлын байранд эмэгтэйчүүд толгойлсон өрхийн гэр бүлийн гишүүдээс авч ажиллуулах санаачлага гаргасан аж ахуйн нэгж, байгууллагуудыг “Нийгмийн хариуцлагаа хэрэгжүүлэгч байгууллага” болгон зарлаж, урамшуулал хөнгөлөлт эдлүүлнэ.
- Өрхийн гишүүдийг нийгмээс асруулагчид биш өөрсдийгөө бие даан авч явах чадвартай иргэн болгон хөгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг сургалтын байгууллагууд, ТББ-уудыг төрөөс тусгайлан дэмжиж, санхүүжүүлнэ.

ШИНЭ АХМАД ҮЕ

Ахмад үед зориулсан бодлого зөвхөн тэтгэврийн бодлогоор хязгаарлагдах ёсгүй. Ахмад үеийнхээ амьдралын арвин туршлага, мэдлэг, чадвар санаачлагыг дэмжин **АХМАД ЗӨВЛӨХИЙН ҮЙЛЧИЛГЭЭ** төрийн байгууллагыг хувийн салбарын үйл ажиллагаанд түшиглэн байгуулна. Үүгээр монгол соёл, монгол чадвар, монгол мэдлэгээ хойч үедээ өвлүүлэн, улмаар дэлхийд түгээх боломжийг нээнэ.

ШИНЭ ЗАСАГЛАЛ – АРД ТҮМНИЙ ЗАСАГЛАЛ

Монголын төр нь хувь хүний эрх, эрх чөлөө, хувийн өмчийн халдашгүй байдлыг дархалсан, монгол хүний тайван, сайхан амьдралын нөхцлийг бүрдүүлэх үүрэгтэй тунгалаг, эрүүл байх учиртай. Өөрөө бүгдийг хэрэгжүүлэгч төр байж, хувь хүнийг төр өөрөөсөө хамааралтай болгох учиргүй.

Хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэмд төр бол ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх зарчмыг баримтлалсан ард түмэнд үйлчлэх олон нийтийн үйлчилгээний алба мөн.

Бид Үндсэн хууль болон Улс төрийн намын тухай, Шүүхийн тухай, Сонгуулийн тухай, Төрийн удирдлага санхүүжилтийн тухай, Төрийн албаны тухай хуулиудыг ард нийтээр хэлэлцүүлсний үндсэн дээр цоо шинэ, ил тод нээлттэй, тунгалаг, шударга төрийн засаглалыг тогтолцоог бүрэлдүүлнэ.

- Улсын Их Хурал дээр хүнтэй холбоотой санал хураалтыг нууцаар шийдвэрлэдэг болгоно.
- Шадар сайд, дэд сайдын албан тушаалыг үгүй болгоно.
- Гэрч, хохирогчийн эрхийг хамгаалах, хөндөгдсөн эрхийг сэргээх эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлнэ.

- Хүний үндсэн эрхийг Үндсэн хуулийн цэц /Үндсэн хуулийн шүүх/ хамгаалж, хангадаг эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлнэ.
- Шүүгчдийг томилдог тогтолцоог боловсронгуй болгож, шүүхийн шийдвэр гаргахад иргэдийн төлөөлөгчийн оролцоог нэмэгдүүлнэ.
- Төрийн бодлогын стратегийн чиглэлд ардчилсан улс төрийн соёлыг төлөвшүүлэх бүхий хүчин зүйлүүдийг тусган хэрэгжүүлнэ. Ардчилалын чухал хүчин зүйл болох хэлцэл хийх, зөвшилцөж чадах, шударга шулуун, ил тод байх чанар, хуулийн өмнө эрх тэгш байдлыг шаарддаг НЭЭЛТТЭЙ зах зээлийг хөгжүүлнэ.
- Нээлттэй эдийн засаг хөгжсөнөөр зах зээл монопольт эрх мэдэл, авлигаас ангижран, шударга өрсөөлдөнт байдалд шилжэн, иргэд зах зээлийн харилцаанд чөлөөтэй, эрх тэгш оролцох нөхцөл бүрдэнэ. Энэ хөгжил нь жинхэнэ ардчилал, сайн засаглалыг бидэнд авчрахад гол түлхүүр болно.
- Нийгмийн шинэчлэл (инновац), нийгмийн капитал, нийгмийн эдийн засагт гол байр суурь эзлэх Иргэний нийгмийн байгууллагыг дэмжинэ.
- Парламентын засаглалыг төгөлдөржүүлнэ. УИХ-ын гишүүн Засгийн газрын гишүүнээр хавсарч ажиллахыг хориглоно.
- Монгол Улсын Их Хурлын сонгуулийг хувь тэнцүүлэх тогтолцоонд бүрэн шилжүүлнэ.
- Парламентад яамдын эрх зүйн бодлогыг хөгжүүлэх асуудал хариуцсан парламентын төрийн нарийн бичгийн дарга нарын бүтэц бий болгоно.
- Парламентын дэд хороодын удирдлагыг цөөнхийн мэдэлд шилжүүлнэ.
- Парламентад төрийн өндөр дээд албан тушаалтнуудын хэргийг шалгадаг Парламентын Мөрдөн шалгах комисс байгуулна.
- Ерөнхийлөгчийн дэргэд Ерөнхийлөгч, УИХ-ын дарга, Ерөнхий сайд байсан улс төрчид, парламентад суудалтай намуудын удирдлага багтсан Үндэсний аюулгүйн өргөтгөсөн Зөвлөл байгуулахыг дэмжинэ.
- УИХ-ыг тараах, УИХ-ын гишүүнийг эгүүлэн татах эрхийг иргэд, сонгогчдод олгоно.
- Орон нутгийн сонгуульд улс төрийн нам, ТББ, иргэд тэгш эрхтэй оролцдог болох нөхцөлийг хуульчилна.
- Иргэд Засаг даргаа өөрсдөө шууд сонгодог, хариуцлага тооцдог, эгүүлэн татдаг болгоно.
- Монгол Улсын бүх хууль, нийтээр дагаж мөрдөх эрх зүйн актуудад үнэлгээ хийж давхцал, зөрчлүүдийг арилгана. Шүүгчийг ард иргэд өөрсдөө сонгодог болгоно.
- Дагнасан шүүхүүд болох Байгаль орчны шүүх, Гэр бүлийн шүүхийг байгуулна.

- Төрийн албан хаагчид алба хашихдаа өсөн дэвших зарчмаар ажилладаг, цалин хангамж нь нэмэгддэг болно. Ингэснээр төрийн албыг сонгуульд ялсан улс төрийн нам бужигнуулдаг зохисгүй хандлагыг өөрчилнө.
- Шүүх, цагдаа, прокурор, гааль, хилийн цэргийн удирдах бүрэлдэхүүнийг залуу боловсон хүчнээр сэлбэнэ. Ротацийн системийг хуульчлан хэвшүүлнэ. Ингэхдээ төрийн албаны ахмад ба залуу үеийн холбоо, төрийн залгамж халааг хатуу баримтална. Энэ салбарын шинэчлэлийг боловсон хүчний шинэчлэлээр эхлүүлнэ. Шинэчлэлийг дээрээс биш, салбарын бүх ажилчид, иргэний нийгмийн хатуу оролцоотойгоор шийдвэрлэх учиртай.
- Төрийн албаны шалгаруулалтыг ил тод болгож шалгалт өгч тэнцсэн хэн бүхний нэрсийн дараалал интернетэд ил тодоор байрлах ба тухайн суларсан орон тоонд нэрсийн дарааллаар очиж ажилладаг байх нөхцөлийг төрийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах замаар хуульчилан шийднэ.
- Нам бол хөгжлийн бодлого боловсруулж түмэн олноосоо дэмжлэг авбал түүнийгээ хэрэгжүүлэхийн төлөө улс орноо удирддаг бодлогын институци, иргэний нийгэм юм.
- Улс төрийн намын дотоод бүтцийг хуульчлан, ардчилсан, нээлттэй байхаар өөрчилнө.
- “Улс Төрийн Намын тухай” хуулинд өөрчлөлт оруулж улс төрийн намуудыг хатуу гишүүнчлэлгүй болгоно.

Хамгийн сайн хяналт бол иргэдийн хяналт

- Амьдарч буй орчныхоо төлөвлөлт, шийдвэрт иргэд өөрсдөө оролцдог Иргэний нийгмийг бүрдүүлнэ. Хувь хүний эрх, эрх чөлөөг зөрчин, амьдарч буй орчинд нь иргэний зөвшөөрөлгүйгээр төлөвлөлт хийх, барилга, зам барих, хүрээлэн буй орчиныг нь сүйтгэдэг тогтолцоог Иргэдийн оролцоот төлөвлөлт, хэрэгжилтийг нэвтрүүлснээр өөрчилнө.
- Байгаль орчноо хамгаалах, нутаг орноо хөгжүүлэхэд оршин суугаа иргэдийн дуу хоолой шийдвэрлэх хүчин зүйл байхаар эрх зүйн орчин, бодлогыг өөрчилнө.
- Алдааг гарсаны дараа нь бус гарахаас нь өмнө илрүүлж, засах иргэний нийгмийн хяналтыг хэрэгжүүлнэ.
- Сум, дүүрэг, аймаг, хот бүр төсвөө нээлттэй тайлагнадаг болж, Иргэдийн хурлыг өргөтгөсөн байдлаар зохион байгуулдаг болгоно.
- Иргэний нийгмийг хөгжүүлнэ. Газар өмчлөл, хувьчлал, барилга, уул уурхайн газрын зөвшөөрлийг баг, хорооны Иргэдийн нийтийн хурлаас олгодог журамд шилжинэ. Газрын алба ИНХ-ын шийдвэрийг бүртгэх л үүрэгтэй болно.

- Төрийн зарим үүргийг ТББ, Мэргэжлийн холбоод, хувийн хэвшилээр гүйцэтгүүлэх ажлыг эрчимжүүлэн, төсвийн 1 хувийн татвараар ТББ Иргэний нийгмийн байгууллагуудыг санхүүжүүлнэ.

ГАДААД ХАРИЛЦААНЫ ШИНЭ ТОГТОЛЦОО

Гадаад харилцааны шинэ тогтолцоо руу шилжинэ.

- Монгол улсын өнөөгийн гадаад харилцааны бодлогод улс орнуудыг эрэмбэлэн жагсаах бодлого барьж байгаа хэлбэрийг өөрчлөн, Монгол улс төвтэй, түүнийг тойрон хүрээлсэн олон туйлт харилцааны шинэ тогтолцоо руу шилжих бодлогыг хэрэгжүүлнэ. Үүгээр монгол улс дэлхийн тавцанд ардчилсан бусад улстай нэгэн дээвэр дор багтаж, шууд харилцах боломж нэмэгдэнэ. Мөн энэ хөгжил нь зөвхөн геополитик гэх нэрийдлээр хоёр хөршөөс хэт хамааралтай байдаг байдлаас ангижруулна.
- Монгол Улсын гадаад харилцааны тогтолцоог эрс шинэчлэн, хоёр үндсэн баганатай бодлого баримтална. Тогтолцооны эхний багана нь геополитикийн шалтгаан дээр суурилсан хоёр хөрш орнууд байна. Эхний баганатай энэ тэнцэхүйц тулгууртай зэргэлдээх багана нь ардчилсан үзэл дээр суурилсан орнууд байна. Ардчилсан үзлээрээ нэгдэж буй орнуудыг гуравдагч хөршийн байрнаас тэргүүлэх тулгуур баганы байр суурь руу оруулж буй нь Монгол улсыг аюулгүй байдал, эдийн засаг, ардчилсан үзэл санааны тал дээр хамтрах олон хөрштэй болох боломжийг олгож байгаа юм. Эдгээр орнуудтай харилцаагаа хөршийн түвшинд хүргэж чадсанаар энэ нь эргээд Монгол улсад хоёр хөршөөсөө ялгарах давуу тал болж, дээрх орнуудаас хөрөнгө оруулалт ихээр татаж, эдгээр ардчилсан орнуудын зөв эдийн засгийн тогтолцоог нэвтрүүлэх, ардчилсан үзэл бодлын сацуу эдийн засгийн харилцан ашигтай хамтрагч болох бүрэн боломжтой болох юм. Хорь гаруй жилийн ардчиллын түүхтэй Монгол Улс өнөөдөр ардчилалаас суралцагч биш, Азид ардчиллыг амжилттай хэрэгжүүлсэн жишиг орон гэдэг байр суурьнаас хандах цаг болсныг ИЗНН тунхаглаж байна. Иймээс ч Монгол улс нь ардчилсан үзэл баримтлалтай, эдийн засгийн хурдацтай өсөлттэй Япон, Өмнөд Солонгостой энэ зэрэгцэх орны байр суурьнаас гадаад бодлогоо шинэчлэн боловсруулж ардчиллын үнэт зүйлс, чөлөөт эдийн засгийн бодлогоороо тэдний хамтрагч нь болох учиртай юм. Дэлхийн тавцанд байр сууриа шинэчлэн бэхжүүлснээр **Монгол Улсын иргэн бүр** буурай орны гэх сэтгэлгээнээс салж, хөгжиж буй орны **иргэний хувьд сэтгэл тэнүүн амьдрах боломж** бүрдэнэ.

Гадаад харилцааны агуулга, мөн чанарыг шинэчлэнэ.

- Гадаад харилцаанд хийсвэр, том, хөрөнгө хүч их зарцуулсан бодлогоос илүү, эх орныхоо эдийн засгийг сонирхлыг дэмжих бодлого баримтлана. Элчин сайдын яамдын үйл ажиллагааг хурал, айлчлал зохион байгуулсны тоогоор бус, эдийн засгийн дорвитой бүтээмж, хөрөнгө оруулалт, худалдааны эргэлтийн хэмжээнд үндэслэн дүгнэдэг тогтолцоонд шилжинэ. Үүнээс гадна, одоогийн элчин сайдуудын яамдуудын байршилд зоригтойгоор өөрчлөлт хийн, эдийн засгийн таатай зурвас үеийг ухаалгаар ашиглахын учир утгыг гадаад харилцааны агуулгад шигтгэн оруулна.
- Монгол ардчилсан орон, иймдээ ч дэлхийн энх тайвны төлөөх олон үйлст хүчин зүтгэх нь бидний олон улсын өмнө хүлээсэн үүрэг. Гэвч буурай орноос хөгжлийн шинэ шатанд дэвших гэж буй бидний хувьд ард иргэдийнхээ өмнө хүлээсэн үүрэг илүү амин чухал юм. Иймээс Монгол улс эдийн засгаа бэхжин тогтворжтол зөвхөн НҮБ-ын мандатын хүрээнд Олон Улсын энхийг сахиулах үйлст оролцон, бусад энхийг сахиулах үйлст оролцохоос түдгэлзэнэ.

Дүгнэлт

САЙХАН АМЬДРАЛ - ТАНЫ СОНГОЛТ

ИЗНН-ын ногоон хөгжлийн эдийн засгийн бодлого гэж нэрлэгдсэн бодлогын баримт бичгийн гол үзэл санаа, үзэл баримтлал, хэрэгжүүлэх арга замын талаар товч дурьдахад ийм байна.

ИЗНН төсвийн бодлого, макро эдийн засгийн бусад үзүүлэлтийн тооцоог дунд болон урт хугацаанд гаргах шаардлагагүй гэж үзлээ. Учир нь эдгээрийн хувьд аль хэдий нь хууль эрх зүйн болон макро бодлогын хүрээнд тооцооны хязгаарлалтууд хийгдсэн. Нөгөө талаас ИЗНН-ын санал болгож буй бүх бодлогууд нь өнөөгийн төсөв-мөнгө, санхүүгийн эх үүсвэрийн түвшинд төсвийн болон бусад эх үүсвэрийг зохистой, үр ашигтай байршуулах, дахин байршуулах бодлогын реформ хийх замаар 2012-2016 онд хэрэгжих бүрэн боломжтой. Гэхдээ өнөөдрийн амьдрал дээр суурилсан асуудлуудыг шийдэхгүйгээр маргаашийн, хэтийн асуудлуудыг сонгогч түмэнд танилцуулах нь эдийн засгийн хувьд бодитой бус, улс төрийн хувьд зохисгүй, амлалт, хүлээлтэд хүргэх сөрөг үр дагавартай гэж үзэж байна.

Энэ хөтөлбөрийн үг үсэг, үзэл санааг сайтар анхааран судалбаас өнгөрсөн 20 жилд улс төрийн намуудаас боловсруулж хэрэгжүүлж ирсэн бодлогоос зарчмын хувьд цоо шинэ хандлагатай, иргэн танаар овоглосон, иргэн таны төлөө, иргэн та өөрөө хэрэгжүүлэхэд нь оролцох гэсэн үзэл санаа, үг үсэг шингээстэй байгаа.

Энэ нь чухамдаа хүн төрөлхтний хөгжлийн өнөөдрийн сонголт болсон даацтай, оролцоотой, тэнцвэртэй хөгжлийн замын гол утга учир мөн.

- Монголын Залуучуудын Холбоо /МЗХ/,
- Монголын Оюутны Холбоо /МОХ/,
- Монголын Сурагчдын Холбоо /МСХ/
- Монголын Скаутын холбоо /МСкХ/
- Монголын Төрийн албан хаагч Залуучуудын холбоо /МТАХЗХ/
- Монголын Мэтгэлцээний Нэгдсэн Нийгэмлэг /ММНН/
- Монголын Лектор төв /МЛТ/
- Монголын Залуучуудын эрхийг хамгаалах төв /МЗЭХТ/
- Монголын МСҮТ, коллежид суралцагчдын холбоо /ММСҮТКСХ/
- Нийгмийн ядуурлын эсрэг- Нэг гэр хөдөлгөөн /Нэг гэр/ болох 10 байгууллагаас ирсэн саналыг дэмжин **ИЗНН-ын Мөрийн хөтөлбөрт оруулах заалтууд**

1. ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙГ ХАНГАХ ТАЛААР

Улс орны хөгжил, ирээдүй өсвөр үе, залуучуудын асуудлыг чухалчлан тэдний эрх ашгийг эрхэм зүйл хэмээн үзэж УИХ-аас "Төрөөс залуучуудын талаар баримтлах бодлого"-ыг боловсруулж батлуулах, хуулийн төслүүдэд залуучуудын нийтлэг эрх ашиг, дуу хоолой, саналыг тусгуулах болон шаардлагатай хуулийн төслүүдийг боловсруулан өргөн бариулах зэрэг ажлыг дэмжин ажиллах;

Хүн амын цонхны үе эхлэж байгаатай холбогдуулан "Төрөөс залуучуудын талаар баримтлах бодлого"-д суурилсан "Залуучуудын хөгжлийн хөтөлбөр"-ийг Засгийн газраар батлуулж, тус хөтөлбөрт залуучуудын гэр бүл, нийгэм, эдийн засаг, эрүүл мэнд, боловсрол, ажлын байр, цалинг нэмэгдүүлэх зэрэг асуудлуудын шийдвэрлэх арга замуудыг тусган Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгуулах;

2. "БОЛОВСРОЛЫН САЛБАРТ ЦАХИМ СУРГАЛТ, МЭДЭЭЛЛИЙН ОРЧНЫГ НЭВТРҮҮЛЖ, СУРГАЛТЫН ЧАНАРЫГ ДЭЛХИЙН ЖИШИГТ ХҮРГЭХ"

Дотоодын их, дээд сургуулиудын сургалтын хөтөлбөрийг олон улсын нэр хүнд бүхий сургуулиудын хөтөлбөрийн стандартад нийцүүлэн шинэчлэх, багшлах боловсон хүчний чадамжийг дээшлүүлэх, багш бэлтгэх тогтолцоонд зарцуулах хөрөнгийн хэмжээ боловсролын салбарт зарцуулж буй нийт хөрөнгийн "Долоон хувьтай тэнцэхүйц" байхаар тооцон, төсөвт тусгах;

3. "СУРАГЧДЫН НИЙТИЙН ТЭЭВРИЙН ХӨНГӨЛӨЛТИЙН ТОГТОЛЦООГ БИЙ БОЛГОХ"

Монголын сурагчдын холбооноос явуулсан судалгаагаар нийслэлийн хэмжээнд 61,123 эцэг, эхчүүд болон 12,211 багш, сурган хүмүүжүүлэгч, 32,600 сурагчид хамрагдаж, сурагчдын өмнө тулгамдсан шийдвэрлэвэл зохих олон асуудлуудаас нэн тэргүүнд нийтийн тээврийн хөнгөлөлтийн тогтолцоог бий болгож, төрөөс санхүүжүүлэх асуудал гэж томъёолсон байна.

Нийтийн тээврийн хэрэгслэлээр ахлах ангийн сурагчид хөнгөлөлттэй үнээр зорчих асуудлыг шийдвэрлүүлнэ

4. "ХАЛАМЖИЙН БОДЛОГО, БЭЛЭН МӨНГӨӨР ДЭМЖИХ ХӨТӨЛБӨРИЙГ ЗӨВХӨН БАГА, ДУНД ОРЛОГОТОЙ ИРГЭДЭД ЧИГЛҮҮЛЭХ"

Монголд бодитоор нүүрлэсэн ядуурлыг бууруулахад анхаарлаа хандуулж, бэлэн мөнгөний дэмжлэг үзүүлэх болон халамжийг зөвхөн "Бага, дунд орлоготой иргэдэд

зориулах" бодлогыг боловсруулж, чиглүүлэх;

Бага дунд орлоготой иргэдэд мэргэжил олгох, ажлын байраар хангах, байнгын баталгаат орлоготой болгоход чиглэгдсэн "Ажилтай, орлоготой иргэн хөтөлбөр"-ийг санаачилж, хэрэгжүүлэх;

5. "АЖЛЫН БАЙРНЫ ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАХ БАЙДЛЫГ ТАСЛАН ЗОГСООХ"

35-аас дээш насны иргэдийг ажил олгогчид ялгаварлан гадуурхаж байгаа бүхий л хэлбэрийг таслан зогсоох хуулийн зохицуулалтыг бий болгож, эдгээр иргэдийг баталгаат ажлын байраар хангахад чиглэгдсэн "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр"-ийг төрөөс тусгайлан боловсруулж, хамрагдах иргэдийн нарийвчилсан судалгааг орон даяар явуулж, төрийн боловсон хүчний нөөцийн санд бүртгэн дэмжих;

6. "ЖИЖИГ, ДУНД, БИЗНЕС ЭРХЛЭГЧДИЙГ ДЭМЖИЖ, ЗЭЭЛИЙН БАТАЛГААНЫ ТӨРИЙН САНГ БАЙГУУЛАН АЖИЛЛУУЛАХ

Жижиг дунд бизнес эрхлэгчдийн үйл ажиллагааг төрөөс төрөл бүрийн хэлбэрээр дэмжиж байгаа боловч тодорхой үйл ажиллагаа нь тогтсон, цаашид нэмэлт зээл авах боломжтой, бизнесийн ажил нь тогтворжсон бизнес эрхлэгчид үргэлжүүлэн их хэмжээний зээл авах тохиолдолд зайлшгүй өндөр үнэлгээ бүхий барьцаа хөрөнгө шаардагддаг бөгөөд түүнийг төр баталгаа гаргах хэлбэрээр дэмжих зээлийн баталгааны төрийн санг байгуулж ажиллана.

ИЗНН, МҮЭ-ИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ САНАМЖ БИЧГИЙН ХҮРЭЭНД
ИЗНН-ын Мөрийн хөтөлбөрт оруулж буй заалтуд

НЭГ.ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

Эдийн засгийн чиглэлээр :

1. Эдийн засгийн хөгжлийн нэгдсэн хөтөлбөртэй болох, эдийн засгийн хөгжлийн яам байгуулан олон тулгуурт, мэдлэгт суурилсан, байгаль орчинд ээлтэй эдийн засгийг хөгжүүлэх,
2. Төсвийн ил тод байдлыг хангах, Үйлдвэрчний эвлэлүүдээс улсын болон салбар, аймгийн төсөв, төлөвлөгөө боловсруулахад оролцох оролцоог нэмэгдүүлэх, зарцуулахад хяналт тавих. Мөн тухайн шатны төсөв, төлөвлөгөө батлагдахаас өмнө хамтын ба тарифын хэлэлцээрийг байгуулдаг байх асуудлыг баталгаажуулах,
3. Дотоодод үйлдвэрлэх боломжтой бүтээгдэхүүний /ноос ноолуур, арьс шир/-ийг анхан шатны боловсруулалт хийсэн байдлаар гаргахыг багасгаж, импортод хязгаарлалт тавих, гаалийн татварыг нэмэгдүүлэх замаар мал аж ахуйн гаралтай түүхий эдийг эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх хөнгөн үйлдвэрүүдийг хөгжүүлэх, бүтээгдэхүүний чанар, стандартыг дэлхийн жишигт хүргэж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх,
4. Ашигт малтмалыг түүхий эд хэлбэрээр экспортод гаргахыг үе шаттайгаар бууруулах, гаалийн татварыг боловсруулалтын шатнаас хамааран тогтоох, нүүрс шингэрүүлэх, нефть, зэс, төмрийн хүдэр, газрын тос боловсруулах үйлдвэр барих, Дарханы нефтийн үйлдвэрийн ашиглалтанд орох хугацааг тодорхой болгох, Асгатын мөнгөний ордыг эргэлтэнд оруулах,
5. Жижиг дунд үйлдвэрлэл эхлэн эрхлэгчдийн үйлдвэрлэлийн техник, тоног төхөөрөмжийг гаалийн татвараас хөнгөлөх, зээл төслийн санхүүжилтийн шалгуурыг багасгаж, зээлийн баталгааны төрийн сангаар дамжуулж дэмжих бодлогыг явуулах,
6. Хувийн хэвшилд үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдэд дэмжлэг үзүүлэх, мэргэжлийн хяналтын байгууллагын зүгээс тэдэнд үзүүлж буй зүй бус дарамт, нөлөөллийг арилгах,
7. Иргэдийн эдийн засгийн мэдлэгийг дээшлүүлэх, хөдөлмөр эрхлэх сэтгэлгээг төлөвшүүлэх, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд менежмент, маркетингийн сургалт явуулах,
8. Уламжлалт мал аж ахуйг хөгжүүлэх, хөдөө аж ахуйн бирж, мал аж ахуйн түүхий эд боловсруулах үйлдвэр байгуулах, органик, экологийн цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэж экспортлох,
9. Газар тариаланг хөгжүүлэх, бүсийн хүнсний хангамжийн бирж, хүнсний үйлдвэр байгуулах, үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх хөтөлбөрт бүсийн нэгдсэн зах зээл бий болгох бодлогыг оруулах, өрхүүдэд ногоо тарих үр өгөх, сургалт явуулах, санхүүгийн дэмжлэг үзүүлэх, айл өрх бүрийг үйлдвэрлэгч болгох зорилт дэвшүүлэн ажиллах,
10. Төвлөрлийг сааруулан төсвийн зардлыг бууруулж, орон нутагт эрх мэдлийг шилжүүлэх, тэдэнд өөрийгөө санхүүжүүлэх боломж олгох,
11. Татварын шатлалтай бодлого хэрэгжүүлэх, татвар буцаалтын бодлогоор иргэд, ААН-ийг урамшуулах,

12. Гадаадын хөрөнгө оруулалттай компаниудад монголын хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах,
13. Хоршоо, нөхөрлөлийн үүсгэл санаачлагыг бүх талаар дэмжих,
14. Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газраас компаниудын шударга бусаар үнэ тогтоож буй эсэхэд хяналт тавих эрхийг баталгаажуулж, хариуцлагыг өндөржүүлэх,
15. Хүн амын хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үнийг төрийн зохицуулалтанд оруулан, хүнсний аюулгүй байдлын хуулийг боловсронгуй болгон ногоон ба цагаан хувьсгалыг өрнүүлэх,

Уул уурхайг хөгжүүлэх чиглэлээр:

1. Ашигт малтмалын лиценз олгох шалгууруудыг өндөрсгөх, хязгаарлах, нөхөн сэргээлтийг стандартын дагуу хийлгэж, байгаль орчинг хамгаалах,
2. Байгаль орчны нөхөн сэргээлтийн чиглэлээр төрийн болон олон нийтийн хяналт шалгалтыг сайжруулах, нөхөн сэргээлтийн өндөр хэмжээтэй барьцаа авдаг, үр дүнтэй нөхөн сэргээлт хийсэн тохиолдолд буцаан олгодог механизм нэвтрүүлэх,

Дэд бүтцийг хөгжүүлэх чиглэлээр:

1. Мянганы замыг эрчимжүүлэн хатуу хучилттай зам болон төмөр замыг хөгжүүлэх, алслагдсан аймгуудын дэд бүтэц, зам харилцааг сайжруулах,
2. Сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлийг бодлогоор дэмжих, эрчимтэй хөгжүүлэхэд бүх талаар анхаарах,
3. Цахилгаан, дулааны хангамжийн найдвартай байдлыг хангах,

ХОЁР. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ХҮРЭЭНД

1. Хөдөлмөр халамж үйлчилгээний газрын бүтэц, зохион байгуулалт үйл ажиллагааг боловсронгуй болгох,
2. Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн нөхцлийг сайжруулах 2012-2016 оны үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг бүрэн хангуулж ажиллах,
3. Залуучууд болон 45-аас дээш насны иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх замаар ажилгүйдлийг бууруулах, нас, хүйс царай зүсээр ялгаварлан гадуурхахыг зогсоох,
4. Гадаадаас ажиллах хүч авах тоонд хязгаар тогтоох, зөвхөн нарийн мэргэжлийн хүмүүсийг урьж ажиллуулах,
5. Түрээсийн байранд үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ эрхэлдэг болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн ажлын байрны түрээсийг бууруулах, хөдөлмөрийн харилцааг зохицуулах,
6. Ахуй үйлчилгээ, хөнгөн үйлдвэр, уул уурхай, барилга зэрэг ажиллах хүч олноор нь шингээдэг салбаруудыг хөгжүүлэх,
7. Өндөр технологийн үйлдвэрлэлийн техник, тоног төхөөрөмж оруулж ирж буй ажил олгогчдод гаалийн татварын хөнгөлөлт үзүүлэх, өндөр технологийн үйлдвэр байгуулж буй ажил олгогч нарыг дэмжих,
8. Хөдөлмөрийн харилцааг зохицуулдаг "Хөдөлмөрийн тухай" хууль, "ҮЭ-үүдийн эрхийн тухай" хууль, "Гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах, гадаадад ажиллах хүч гаргах тухай" зэрэг хуулийн хэрэгжилтийг хангуулах,
9. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, албан бус салбарт хөдөлмөр эрхлэгчдэд бодитой дэмжлэг үзүүлэх,
10. Иргэдэд үндсэн ажлынхаа зэрэгцээ цагийн ажил хийж амьдралаа дээшлүүлэх эрх зүйн орчин бүрдүүлж өгөх,

ГУРАВ.ЦАЛИН ХӨЛС, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ХҮРЭЭНД

1. Цалин, тэтгэвэр, тэтгэмжийг инфляцийн түвшин болон үнийн өсөлттэй уялдуулан шинэчлэн тогтоох итгэлцүүрийг бий болгож нэмэгдүүлэх,
2. Хөдөлмөрийн харилцаанд шударга ёсыг тогтоох, ижил хөдөлмөрт адил цалин хөлс олгох зарчмыг хэрэгжүүлэх,
3. Соёл урлагийн салбарт ажиллагсадын хөдөлмөрийн үнэлэмжийг тусгайлан нэмэгдүүлэх,
4. Бүтээмжийн хөдөлгөөнийг үндэсний хэмжээнд өрнүүлж үр дүнд хүргэх,
5. Нийгмийн даатгалын шимтгэлийг нөхөн төлөх замаар хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг нийгмийн даатгалд хамруулах зохицуулалтыг бий болгох,
6. Халамжийг хавтгайруулан олгодгийг зогсоон зорилтот бүлэгт чиглүүлэх,
7. Нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын тогтолцоог боловсронгуй болгох замаар хөгжүүлэх, сангийн зарцуулалтыг ил тод болгох,
8. Ядуурлын түвшинг бодитой тогтоох аргачлалыг боловсронгуй болгох

ДӨРӨВ.БҮС НУТГИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ХҮРЭЭНД

1. Бүсийн хөгжлийн концепци боловсруулан хэрэгжүүлэх, ногоон эдийн засгийг хөгжүүлэх, экологийн тэнцвэрт байдлыг хадгалах, нийт нутгаар мод тарьж ойжуулах,
2. Бүс нутгийн газар зүйн байршил, онцлог, давуу тал дээр түшиглэсэн аялал жуулчлал хөгжүүлэх, аялал жуулчлалын маршрут гаргаж, олон улсын хэмжээнд хүргэх,
3. Бүсийн оношлогоо эмчилгээний төвүүдийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах,
4. Чанартай, хямд үнэтэй өргөн хэрэглээний бараагаар иргэдийг хангах, худалдаа, борлуулалтын сүлжээ байгуулах, ченжийн худалдааг халах,
5. Сум дундын тэжээлийн фонд байгуулах,
6. Хүн амын шилжилт хөдөлгөөнийг сааруулахын тулд сумдыг хөгжүүлэх, барилгажуулах, сум багуудад ажиллах мэргэжилтнүүдийг дэмжих, амьдралын нөхцлийг сайжруулах
7. Орон нутгийн иргэдийн саналаар уул уурхай, замын төслүүдийг хэрэгжүүлдэг байх, ашигт малтмалаас олж буй орлогын зохих хэсгийг нутгийн иргэд, нутгийн захиргааны байгууллагад үлдээх,
8. Аймаг, орон нутгийн иргэдийн саналаар аймаг, сумдын засаг даргыг сонгодог болох,
9. Нутгийн иргэдийн худалдан авах чадварт тохирсон орон сууцжуулах хөтөлбөр хэрэгжүүлэх,

ТАВ.ХҮНИЙ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ХҮРЭЭНД

1. Орон нутагт эрүүл мэнд, боловсролын салбарт ажиллах боловсон хүчний чадавхийг дээшлүүлэх замаар боловсролын чанар хүртээмжийг дээшлүүлэх,
2. Эрүүл мэндийн салбарын эмчилгээ, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулж, санхүүжилтийн тогтолцоог боловсронгуй болгох,
3. Хүнсний аюулгүй байдлыг хангах төрийн бодлогыг боловсронгуй болгож, импортоор орж ирж буй хүнсний бүтээгдэхүүнд тавих хяналтыг сайжруулах, гарал үүслийн баталгаагүй хүнс, жимс жимсгэний бүтээгдэхүүнийг ганзагын наймаагаар оруулдгийг зогсоох,
4. Их дээд сургуулиудын сургалтын чанарыг дээшлүүлэх,

5. Эрүүл мэндийн анхан шатны эмчилгээ, үйлчилгээг үнэ төлбөргүй болгох, эрүүл мэндийн санхүүжилтэнд хөндлөнгийн хяналт тавих,
6. Хүн ам зүйн нэгдсэн бодлоготой болох,
7. Монгол хүний онцлогт тохирсон боловсролын урт хугацааны тогтвортой бодлогыг баримтлан ажиллах,
8. Хүн амын дунд нийтийн биеийн тамир, спортыг хөгжүүлэн өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрүүлжүүлэх, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх орчин бүрдүүлэх,
9. Үндэсний зан заншил, хэл соёлыг хадгалах тухай хөтөлбөрийг дунд сургуулийн сургалтын хөтөлбөрт оруулах,
10. Уул уурхайн салбар хөгжиж буй бүс нутагт хүн амын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж буй хөрсний бохирдолт, усны хомсдол, бохирдолт, тоосжилт зэрэг сөрөг нөлөөллийг тогтмол шинжлэх лабораториудыг байгуулан, хүн амын эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр төрөөс анхаарч ажиллах,

ЗУРГАА.НИЙГМИЙН ТҮНШЛЭЛИЙГ ХӨГЖҮҮЛЭХ ХҮРЭЭНД

1. Нийгмийн түншлэлийн гурван талт харилцааг хөгжүүлэх хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх, нийгмийн түншлэлийн уулзалтыг бүх түвшинд жил бүр хийж хэвших, өндөр хөгжилтэй орнуудын нийгмийн түншлэлийн талаар туршлага судлах
2. Хамтын болон тарифын хэлэлцээр, хамтын гэрээний хамрах хүрээ, хэлэлцээрт оролцогч талуудын үүрэг хариуцлагыг тодорхой болгох,
3. Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хороог УИХ-ын дэргэд байгуулах,
4. Донор орнуудаас нийгмийн салбарт хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрүүдэд нийгмийн түншлэгч талуудын оролцоог хангах,
5. Нийгмийн түншлэлийг хөгжүүлэх үйл ажиллагааг санхүүжүүлэх төсөв хөрөнгийг улсын болон салбар орон нутгийн төсөвт тусган ажиллах

**МОНГОЛЧУУД АА! ЭХ ОРОНДОО ЭЗЭН НЬ БОЛЖ, ЭРҮҮЛ САЙХАН
АМЬДАРЦГААЯ.**

ИРГЭНИЙ ЗОРИГ НОГООН НАМ

---oOo---